

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДӨР, БААСАНГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Баасан гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-46

- 
- 1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг** 5-46

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы  
11 дүгээр сарын 22-ны өдөр /Баасан гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 67 гишүүн хүрэлцэн ирж, 53.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 06 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Батшугар, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярбаатар, Б.Бейсен, Э.Болормаа, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Х.Жангабыл, Б.Жаргалан, Ц.Мөнхбат, П.Мөнхтулга, Н.Наранбаатар, С.Одонтуяа, Б.Тулга, Б.Хэрлэн, С.Цэнгүүн, Ж.Чинбүрэн, Ж.Энхбаяр;

Чөлөөтэй: Х.Баасанжаргал, Ц.Баатархүү, Б.Батцэцэг, Л.Гантөмөр, М.Нарантуяа-Нара, Г.Очирбат, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут, Х.Болормаа, Э.Одбаяр;

Тасалсан: Н.Алтаншагай, Б.Батбаатар, Х.Баттулга, Ц.Даваасүрэн, Х.Тэмүүжин;

Хоцорсон: О.Алтангэрэл-19 минут, С.Амарсайхан-08 минут, О.Амгаланбаатар-1 цаг 54 минут, П.Батчимэг-10 минут, Х.Булгантуяа-57 минут, Г.Ганбаатар-01 минут, Д.Ганбат-03 минут, М.Ганхүлэг-03 минут, Т.Доржханд-14 минут, Б.Жавхлан-01 минут, Б.Заяабал-03 минут, З.Мэндсайхан-02 минут, П.Наранбаяр-04 минут, Ч.Номин-15 минут, Д.Рэгдэл-1 цаг 48 минут, Ц.Сандаг-Очир-03 минут, Н.Учрал-16 минут, Д.Цогтбаатар-25 минут, Б.Чойжилсүрэн-01 минут.

**Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга Ж.Мөнхболд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын Хууль зүйн дүн шинжилгээний хэлтсийн дарга М.Үнэнбат, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх А.Болортуяа, Ё.Энхсайхан, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, Төсвийн байнгын хорооны ажлын албаны референт Б.Мөнгөн-Аргамж, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Я.Эрдэнэсамбуу нар байлцав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын

Их Хурлын гишүүн Т.Аубакир, Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нар танилцуулав.

Танилцуулга болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, О.Цогтгэрэл, Б.Пунсалмаа, Б.Энхбаяр, П.Сайнзориг, Р.Батболд, Л.Мөнхбаясгалан, Ө.Шижир, С.Эрдэнэбат, Ж.Баярмаа, М.Бадамсүрэн, Ж.Баясгалан, О.Номинчимэг, Ч.Лодойсамбуу, Б.Батбаатар, Н.Номтойбаяр, З.Мэндсайхан, Д.Ганбат, Б.Түвшин, Г.Тэмүүлэн, С.Амарсайхан, У.Отгонбаяр нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Б.Даваадалай, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж нар хариулж, тайлбар хийв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хороодын саналаар, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль, тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	70
Татгалзсан:	19
Бүгд:	89

78.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Т.Доржханд, Д.Ганбат, П.Батчимэг, Р.Сэддорж, О.Цогтгэрэл нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 86.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах саналыг дэмжсэн тул “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсанд тооцов.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулах нь зүйтэй гэсэн горимын санал гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийн олонх дэмжив.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /17:30/

*Уг асуудлыг 17 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 2 цаг 26 минут үргэлжилж, 126 гишүүнээс 89 гишүүн хүрэлцэн ирж, 70.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 32 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
15 цаг 06 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая 67 гишүүн ирцэд бүртгэгдэж, ирц 53,2 хувьтай болсон байна. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар 1 асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж, баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэнэ.

**Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж, баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэж эхэлье.**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Гомбожавын Занданшатар танилцуулна. Индэрт урьж байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Занданшатар дарга хаана байна. Занданшатар даргыг индэрт урьж байна.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хуулийн 33.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж, баталсан хууль тогтоомжид бүхэлд нь хориг тавьсан хориг тавьсан. Үндэслэлүүд:

1 дүгээрт, гадаад зах зээлийн төлөв байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлийг харгалзан гадаад валютын улсын нөөц, төсвийн хуримтлалыг нэмэгдүүлэх, өрийг бууруулах зэрэг суурь зарчмуудыг анхаарч, мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлж, алдагдалгүй төсөв батлах нь зүйтэй гэж үзсэн. Олон улсын геополитик геостратегийн нөхцөл байдлаас шалтгаалж гадаад эдийн засгийн төлөв байдал урьдчилан таамаглах боломжгүйгээр хувьсан өөрчлөгдөж, түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ ханшийн хэлбэлзэл өндөр байна. Энэхүү эгзэгтэй цаг үед мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй, хөгжилд хөтөлсөн төсөв төлөвлөж батлах нь нийт иргэн, улсын ашиг сонирхолд бүрнээ нийцнэ гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурал 2025 оны улсын төсвийг хэлэлцэн батлахдаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, хуулийн 6.5.1-д заасан “төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын

талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх”, мөн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан “төсвийн бодлого стратегийн зорилт нь макро эдийн засгийн болон татварын тогтвортой орчныг бүрдүүлэх, инфляцыг хязгаарлахад чиглэгдсэн байна.”, 5.1.6-д заасан “төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх” гэсэн заалтуудыг бүрэн хангаагүй бөгөөд энэ байдал нь хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчимд нийцэхгүй байна. Үүний зэрэгцээ Улсын Их Хурлаар саяхан баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төсвийн алдагдалд Засгийн газрын тусгай шаардлагыг хангана гэсэн зорилтоо бодитой хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тэргүүн сануулж байна.

Мөн ард иргэд, баялаг бүтээгч, татвар төлөгчид болон мэргэжлийн байгууллагуудын зүгээс төсвийн сахилга батыг чангатгах, үр ашигтай, хэмнэлттэй байх нийтлэг зарчимд нийцүүлэн төсвийн зардлыг бууруулах, чиг үүргийн давхардлыг арилгах, улс төрийн нам, эвслүүд сонгуульд амласан амлалтаа биелүүлэх зэрэг санал шүүмжлэлийг илэрхийлж байгаа нь зүй ёсны шаардлага хэмээн үзэж байна.

2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль тогтоомжууд нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байна гэж үзэж байна.

Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 41 дүгээр тогтоолыг баталсан. Энэхүү тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль нь Төсвийн болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан зарчмуудыг бүрэн хангаагүй, төрийн мөнгөний бодлогод нийцээгүй, төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж чадаагүй болохоо хүлээн зөвшөөрч, батлагдсан төсвийг тодотгож, дахин засаж сайжруулах шаардлагатай гэсэн агуулгыг илэрхийлсэн байна.

Мөн Монгол Улсын төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт “Засгийн газар дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголын төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.” гэж тусгайлан заасан.

Гэтэл Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль хүчин төгөлдөр болж, дагаж мөрдөж эхлээгүй байхад Төсвийн тухай хуулийн 34.1-д заасан нөхцөл байдал тохиолдол үүсээгүй байхад Монгол Улсын Их Хуралд төсөвт тодотгол хийхээр тогтоол баталж, чиглэл болгож байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” хэмээх заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байна гэж үзэж байна.

Иймд дээр дурдсан үндэслэлүүдээр Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан хоригийг холбогдох хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Занданшатар даргад баярлалаа. Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Телеуханы Аубакир танилцуулна. Индэрт урьж байна.

**Т.Аубакир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжид Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Төсвийн байнгын хороо Ерөнхийлөгчийн хоригийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасныг баримтлан 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад зах зээлийн төлөв байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлийг харгалзан гадаад валютын улсын нөөц, төсвийн хуримтлалыг нэмэгдүүлэх, өрийг бууруулах суурь зарчмуудыг анхаарч, мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлэн алдагдалгүй төсөв батлах, мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төсвийн урсгал зардлын тэнцлийг хязгаарлаж, төсвийн алдагда, Засгийн газрын өрийн тусгай шаардлагыг хангах зорилтуудаа хэрэгжүүлэх нь зүйтэй талаар хоригийн үндэслэлдээ дурджээ.

Байнгын хорооны хуралдаанаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авснаар урсгал зардлыг бууруулах, алдагдалгүй төсөв батлах, төгрөгийн ханшийг тогтворжуулах боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал Төсвийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг боловсруулан баталж, орон нутагт төсвөө батлах цагалбарыг өөрчлөх, төсвийн урсгал зардалд дүн шинжилгээ хийж, тэнцлийг сайжруулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авч төсвийн ур урсгал зардлыг бууруулах шаардлагатай, мөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан нийгмийн ач холбогдол бүхий Хавдар судлалын эмнэлгийн барилгын санхүүжилтийг шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар урсгал зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтыг эрэмбэлэх нь зүйтэй бөгөөд цаашид Улсын Их Хурлын хуралдаанаар Улсын Их Хурлаар батлагдаж байгаа хууль тогтоомжоор төсөвт ачаалал нэмэгдүүлж байгааг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайхан макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, төсвийн бодлогоор хувийн хэвшлүүдийг дэмжих нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулан төсвийн зардлын өсөлтийг хязгаарласан төсвийн тусгай шаардлагуудыг өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Ерөнхийлөгчийн хоригийг дэмжиж байгаа бөгөөд цаашид уул уурхайн бүтээгдэхүүний үнийн өсөлттэй хамааралтай төсвийн тэлэлтийг зохистой түвшинд хязгаарлах нь зүйтэй талаар үг хэлсэн болно.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол



Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос дээш буюу 94,7 хувь нь хүлээж авах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Аубакир гишүүнд баярлалаа. Хууль зүйн байнгын хороо дөнгөж саяхан хуралдсан учраас одоо орж ирж байна. Дүгнэлт нь. Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

**О.Номинчимэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн мөн холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцлээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Байнгын хорооны хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Занданшатар танилцуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваагийн Цогтбаатар хоригын 1 дүгээр зүйлд тусгагдсан мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх гэдэг нь нэр томъёоны хувьд ямар утга санаа илэрхийлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн агуулгад 2025 оны төсвийн алдагдлыг бууруулах, эсвэл алдагдалгүй төсөв батлах гэдэг шаардлагын алийг тавьж байгаа талаар, хоригтой холбогдуулан 2025 оны төсвийн хуулийг дагаж баталсан төсвийн тодотголын талаарх Улсын Их Хурлын тогтоол хэрхэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл нь холбогдох хэд хэдэн хууль тогтоомж зөрчиж байгаа талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлт дээр дурдсан байдаг бөгөөд төсөв хэлэлцэх үед энэ талаар удаа дараа хэлж сануулж байсан гэдгээ илэрхийлж Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан тохиолдолд Засгийн газарт буцааж болох хууль эрх зүйн гарц байгаа эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат 2025 оны төсөл дэх мега төслүүдийн талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.

Мөн хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Ерөнхийлөгчийн хоригт 2 асуудлаар Үндсэн хууль зөрчсөн талаар дурдсан. Үүнтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хороо дүгнэлт гаргах шаардлагатай талаар, Төсвийн хууль

хүчин төгөлдөр мөрдөгдөж байхад тогтоол баталсан нь Үндсэн хууль зөрчсөн бөгөөд хууль дээдлэх зарчим алдагдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Д.Цогтбаатар, П.Сайнзориг, Г.Уянгахишиг нар байр сууриа илэрхийлж тус тус үг хэллээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр буюу 100 хувийн саналаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Батсуурийн Даваадалай Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх, Жаргалсайханы Мөнхболд Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирсэн байна.

Ингээд Ерөнхийлөгчийн хориг болон Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгье. Ирцийн дарааллаар Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Алдаржавхлан:** Баярлалаа. 3 асуулт байна.

1 дүгээрт Ерөнхийлөгчийн хоригийг ингээд хүлээгээд бараг авах юм шиг байна. Тэгээд Ерөнхийлөгчийн хоригийг хүлээгээд авах юм бол аймаг, нийслэлийн төсөв 12 сарын 5-ны өдөр баталсан байх ёстой. Сум, дүүргийн төсөв 12 дугаар сарын 20-ны дотор баталсан байх ёстой. Энийг хэд хоногоор хойшлуулах тухай эрх зүйн гарц байна уу. Энийг холбогдох хүмүүсээс нь асууя.

2-т нь Сангийн сайдаас та бүгд ер нь Ерөнхийлөгчийн хориг ирнэ гэсэн ийм хүлээлт байсан уу. Ерөнхийлөгчөөс хориг ирнэ гэсэн хүлээлт байсан уу. Та бүгдэд хувилбар байгаа юу. Бэлдсэн хувилбар энэ тэр байна уу гэсэн ийм зүйлийг асуумаар байна.

3-д нь би сая Хууль зүйн байнгын хорооны хурал дээр хэлсэн юм. Энэ дэгийн хуульдаа хэдүүлээ өөрчлөлт оруулахгүй бол зарим хүмүүс нь энэ ердийн горимоор хэлэлцэнэ гэж байна лээ. Зарим ухаантай хүмүүс нь энэ төсвийн хэлэлцдэг зарчмаар хэлэлцэнэ гэсэн. Тэгэхээр эхний ээлжид дэгийн хуульд өөрчлөлт оруулаад яг энэ төсөв хүлээж аваад хоригийг хүлээж авсан нөхцөлд яаж хэлэлцдэг вэ гэсэн энэ заалтыг нэг тийш нь болгохгүй бол маш их маргаан үүсэхээр ийм юм ажиглагдсан. Энийг эхлээд хариултыг аваад дараа нь тодруулъя.

**Д.Амарбаясгалан:** Занданшатар дарга хариулах уу эхний асуултад нь.

**Г.Занданшатар:** Тэгээд энэ асуултад бол би яг хариулахгүй. Хаяг нь буруу байх. Гэхдээ Төсвийн тухай хуулиар 12 сарын 5-ны дотор орон нутгийн төсөв, нийслэл, аймгууд батлах ёстой. Өчигдрийн байдлаар өргөн мэдүүлсэн байх ёстой. Тийм учраас энийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасны дагуу хориг хүлээн авсантай холбогдуулан Төсвийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ингээд энэ цаг хугацааны асуудлыг бол зохицуулах болом боломжтой гэж үзэж байна. 1 дүгээрт.

Ер нь бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт 2024 оны 11 дүгээр сарын 19-ний 9 цаг 17 минутад Төсвийн тухай хууль ирсэн. 20-ны өдрийн 10 цагт 1 өдрийн дотор л энэ хоригийн асуудал шийдэгдэж, тавигдсан. Бусад хугацаатай холбоотой асуудал бол тэгэхээр Улсын Их Хурал дээр шийдэх бололцоотой гэж үзэж байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан. Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад хариулъя. 11 сарын 8-нд Улсын Их Хурлаар 2025 оны төсөв батлагдаж дууссан. Тэгээд дууссантай зэрэгцээд, ондоо багтаагаад тодотгол эргэж өргөн барих ийм үүргийг Засгийн газарт өгсөн. Тийм учраас тэр өдрөөс хойш бид юу гэж зүгээр суух вэ. Эндээ бэлтгэл ажлаа хангаад ингээд тооцооллуудаа бол хийгээд сууж байгаа. Тооцооллын түвшинд. Мэдээж яг хууль эцэслэн батлах хугацаа, өдөр бол дэгтэй. Соёрхон батлах хугацаа, улмаар Ерөнхийлөгчийн хориг тавих хугацаа гээд. Тэрний дараа хориг ирэх үү эсвэл тодотголоор явах уу гээд энэ нь тодорхой болдог. Энэ удаа ингээд Ерөнхийлөгчийн хориг тавих хугацаанд Төрийн тэргүүн хориг тавьсан учраас үүний дагуу Засгийн газар оролцоод явахад бол бэлэн байгаа.

**Д.Амарбаясгалан:** Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууж, үг хэлнэ.

**О.Цогтгэрэл:** 2025 оны төсөвт Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүхэлд нь тавьсан хоригийг намын бүлгүүд, харьяалах Байнгын хороод бас өндөр хувийн саналтайгаар хүлээж авч байгаад бас талархаж байгаа.

Ер нь бас яагаад ийм нөхцөл байдал энэ төсөв дээр үүсчэв ээ гэдэг дээр бид нар бас эргэж харах ёстой байх гэж бодож байна. Зөвхөн энэ жил 2024 оны төсөв, баталсан 2025 оны төсөв 2-ын хооронд 27-гоос 35 буюу 30 хувийн өсөлт гарчхаад байгаа юм. Төсвийн тэлэлт 30 хувь. Эдийн засгийн өсөлтөөсөө 5-6 дахин өндөр өсөлт зөвхөн төр дээр, төсөв дээр аваачаад бид нар өнгөрсөн хугацаанд гаргачихсан. Гэтэл энэ хугацаанд ард иргэд бас яагаад нийтээрээ дургүй байна вэ гэхээр энэ хугацаанд нөгөө нэг хэмжүүр болсон ядуурал гээд үзүүлэлт чинь 1 хувиар ч буураагүй. Төрийн зардал хэдэн их наядаар нь 30, 40 хувиар нэмэгдээд байхад иргэдийн орлого нь нэмэгддэггүй. Энэ эдийн засгийн машиныг л иргэд дургүйцэж байгаа ийм л нөхцөл байдал. Эдийн засгийнхаа өсөлтөөс 5-6 дахин томоор төрийн зардал нь тэлж байдаг ийм л нөхцөл байдалд ард иргэд бас ихээр дургүйцсэн болов уу гэж боддог.

10 сарын 31-нд Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг би бас танилцуулж байсан. Энэ дээр бид нар бас 1 дүгээрт орлого, зарлагыг оновчтой болгож, Монгол Улсын 2025 оны төсвийг алдагдалгүй батлах тухай, хөрөнгө оруулалтын төслүүдийг ач холбогдлоор нь зөв эрэмбэлэх тухай, нэн шаардлагагүйг нь хасах тухай, 3 дугаарт нь намуудын ард түмэнд амласан мөрийн хөтөлбөр болоод Засгийн газрын гэрээний заалтаа биелүүлэх гэдэг ийм санал, дүгнэлтүүдийг Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлт дээр бас сая 10 дугаар сарын 31-нд танилцуулж байсан.

Тэгэхээр энэ бүгд бүгдээрээ л яг нөхцөл байдал бас ямар болохыг тал талын байр сууриуд нэг л байсан. Засгийн газар асуудлыг арай өөрөөр харсан. Хамгийн гол нь энэ бүгд бид нар явсаар байгаад төрийн мөнгөний бодлого, төсвийн бодлого, олон олон зүйл төрийн өмчит компани, төрийн алба энэ бүх зүйл маань иргэдийн амьдралын тэр өсөж байгаа, дээшилж байгаа хурдаас чинь 5-6 дахин томроод байгаа учраас л асар их дургүйцэл үүний цаана байжээ гэж бас ойлгодог.

Тэгэхээр эндээс 1 асуулт гараад байгаа юм. Мэдээж хоригийг ингээд хүлээж авах юм байна. Тэгэхээр энэ хоригийг хүлээж авах чинь өөрөө 1 удаагийн энэ жилийн төсөв ард иргэд бас энэ дээр ач холбогдол өгөөд, олон нийт ач холбогдол өгөөд ингэж байна. 1 удаагийнх болчхоод. Цаашид энийгээ бид нар яах билээ. Цаашид дахиад жилд 30 хувь өсдөг энэ тогтолцоо маань хэвээрээ байгаад байх юм уу. Тогтолцоогоо бид нар яаж өөрчлөх юм.

Сая 8 дугаар сард баталсан Төсвийн тогтвортой байдлын хуулийн өөрчлөлтөөр энэ бүгдийг аваад хаячихсан шүү дээ. Ингэж замбараагүй нэмж болдог үүд хаалга, цонхыг нь нээгээд хаячихсан. Тэгэхээр энийг бид нар гол нь энэ төсвийн хоригийг хэлэлцэхээс гадна, энийг хүлээж авахаас гадна цаашдын энэ үүд хаалгаа яаж хаах ёстой билээ. Энэ дээр ер нь холбогдох Байнгын хороо болоод энэ мэдээж Ерөнхийлөгчийн тамгын газраас энэ дээр хариулах ёсгүй байх. Энэ дээр ямар бодлого барьж ажиллах ёстой вэ гэдэг дээр хариулт авмаар байна.

Гол нь энэ чинь тогтолцоогоо дахиж энэ зүйл гарахгүй байх гэдэг зүйлийг засах нь өөрөө энэ хууль тогтоох байгууллагын үндсэн үүргүүдийн 1 байх гэж бодож байна. Ердийн тэр хориг саадуудыг авч хаяагүй байсан бол бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт олон зүйлтэй харьцуулахад төсвийн зарлагын өсөлтийг магадгүй 6, 7 хувиас дээш нэмэх боломжгүй байсан хязгааруудыг л аваад хаячихсан шүү дээ. 8 сард авч хаягчаад 9 сарын 1-нд өргөн барьсан төсөв чинь өөрөө 30 хувийн өсөлтийг л тэр үед л хаалга, цонхыг нь нээчихсэн. Тэгэхээр энэ хоригоосоо гадна энэ хаалга цонхоо яаж бид нар багасгаж, хааж битүүлэх ёстой юм бэ. Энэ дээр 1 хариулт өгөөч.

**Д.Амарбаясгалан:** Ер нь энэ төсвийн төслөө боловсруулж, өргөн барих хэлэлцүүлэгтэй холбоотой асуудал дээр Сангийн сайд ер нь бас нэг байр сууриа илэрхийлэх нь зөв байх. 8 сард төсвийн тодотгол гэж орж ирж бас гишүүдийг баахан бухимдуулсан. Өчнөөн талцал болсон. Тэгээд мэдээж гишүүд олон талаас хэлэлцэж, олонхоороо асуудлаа шийдээд явсан. 9 сарын 1-нд дараагийн төсөв өргөн баригдсан. Өнгөрсөн хугацаанд Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарсан. Мэргэжлийн Байнгын хороод дээр асуудлыг хэлэлцсэн. Гишүүдийн саналыг бүтээлчээр хүлээж аваад, зарим төрлийн өөрчлөлт өнөөдөр нийгэмд үүсгээд байгаа шүүмжлэлүүдийг засаж залруулах боломж хангалттай байсан боловч Засгийн газрын өргөн барьсан төслөөр нь дэмжих ёстой гэсэн улс төрийн намуудын,

бүлгүүдийн зарим байр сууриуд гарсан учраас энэ асуудал ингээд өнөөдөр шийдэгдээд явчихсан.

Энд бас нэг ноцтой зүйл бас яригдаж байгаа юм. Улсын Их Хурлын авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотой гарсан тогтоолыг Төсвийн байнгын хороо санаачилж оруулахдаа 2025 оны 1 дүгээр улиралд багтааж төсвийн тодотгол хөндөнө гэдэг төсөл оруулсан. Тэр дээр нэр бүхий гишүүд, асуудал хариуцсан сайд ондоо багтаж тодотгол хийе гэдэг санал гаргаж, хугацааг өөрчилсөн. Тэгээд өнөөдөр Их Хурлынхаа баталчихсан тогтоолыг өөрсдөө Үндсэн хууль зөрчсөн мэтээр ярьж явж байгаа бас энэ зохимжгүй зүйл бас энд гарч ирж байна. Тийм учраас энэ өргөн барьж байгаа асуудал, хэлэлцэж байгаа асуудал, энэ асуудалдаа эзэн болох гэдэг энэ асуудал дээрээ маш тодорхой байр суурьтай байх ёстой. Бид бас сая Цогтгэрэл даргын хэлж байгаа энэ төсөв хэлэлцэхтэй холбоотой асуудлуудаар Булгантуяа Их Хурлын дэд даргаар ахлуулсан 25 орчим гишүүн орсон том ажлын хэсэг байгуулагдсан. Энэ бол бас бодитой дүн шинжилгээ хийгээд, ажил нь явагдаад эхэлж байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье. Бадамдоржийн Пунсалмаа гишүүн. Сангийн сайд хариулт өгөх үү. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. 8 сард Монгол Елсын хамтарсан Засгийн газрын 2028 он хүртэлх төлөвлөгөөтэй зэрэгцээд Засгийн газрын гарааны 2024 оны сүүлийн хагас жилийн төсөв дээр тодотгол хамт өргөн баригдсан. Өөрөөр хэлбэл энэ төлөвлөгөөг цаг алдалгүй биелүүлэх, гараанаас нь амжилттай гаргах ийм л тодотгол байсан. Улсын Их Хурал дээр тодотголыг хэлэлцээд ингээд баталсан. Мөн үүнтэй яг зэрэгцээд хамтарсан Засгийн газрын 2025 оны буюу анхны бүтэн жилийн төлөвлөгөөг мөн өргөн барьсан байгаа. Энэ төсвийн гол үзэл баримтлал бол ойрын жилүүдэд төлөвлөгөөндөө хүрэх томоохон макро эдийн засгийн өсөлтийн хөгжлийн зорилтууддаа хүрэх, тэгэхдээ энэ нь бол бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал дээр суурилах юм гэдэг ийм л зорилгоор өргөн баригдсан төсөв байгаа. Тодотгол болон ингээд 2025 оны төсөв дараалаад орсон учраас энэ дээр бол төсвийн өсөлт, тэлэлт байгаа. Энийг дагаад мөн дотоодын нийт бүтээгдэхүүн сүүлийн 4 жилийн дотор 2,5 дахин өссөн байдаг. Ингээд эдийн засгийн идэвхжил өөрөө бий болж байгаа учраас мөн төсвийн орон зай бол нэмэгдэж байгаа. Гэхдээ төсөв дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа ер нь 1/3 гэдэг энэ харьцаа дээрээ сүүлийн 20-иод жил бол хэвээрээ тогтвортой явж байгаа. Төсвийн урсгал зардал нэмэгдсэн 3,5 их наядыг задлаад харах юм бол энд маш тодорхой зүйлүүд байгаа. Үнийн өсөлттэй холбоотой зүйлүүд байна. Үйл ажиллагааны өргөжсөн тэлсэн зүйлүүд байна. Дээрээс нь мөн хууль тогтоомжийн дагуу шууд нэмэгдэж байгаа, мөн олон үйл ажиллагааны салбар салбарын ийм зардлууд байгаа.

Өөрөөр хэлбэл Засгийн газар өөрийн тавьсан томоохон макро зорилтууд дээрээ энэ 4 жилийн хугацаандаа о цаг алдалгүй хүрье гэдэг нэлээн амбицтай, том зорилт тавьсан. Том зорилт тавьсан байгаа. Харин одоо Ерөнхийлөгчийн хориг дээрээс харвал ойрын хугацаанд гадаад нөхцөл байдал нэлээдгүй өөрчлөлт орж байна. Эндээс харах юм бол Засгийн газрын хувьд тавьсан томоохон зорилтдоо яаралтгүй байна. Эдгээр эрсдэлүүдийг тооцож, харин тогтвортой макро тэнцлүүдээ бариад ингээд алгуурхан явах, гэхдээ хүрэх энэ зорилтуудаасаа ухарч болохгүй гэдэг ийм шаардлагуудыг тавьж байна гэж бид ингэж харж байгаа.



Дээрээс нь Улсын Их Хурал дээрээс 2025 оны төсөв батлагдсантай холбогдуулж гарсан тогтоол дээр бол бидний зүгээс Үндсэн хууль зөрчсөн ч гэдэг юм уу ямар нэг ийм байр суурь бол илэрхийлээгүй шүү Их Хурлын дарга аа.

**Д.Амарбаясгалан:** Бадамдоржийн Пунсалмаа гишүүн. Цогтгэрэл гишүүн тодруулж асууя. Одонгийн Цогтгэрэл гишүүний микрофон өгье.

**О.Цогтгэрэл:** Сангийн сайдын байр суурь дээр бас гишүүд янз бүрийн бодлуудтай л байгаа байх. Төсвийг 8 сард хэт их тэлнэ гэдэг тэр үүд хаалгыг нээхээд 9 сарын 1-нд асар их 30 хувь тэлсэн төсөв оруулж ирчхээд, тэрийг нь олон нийтийн хэлэлцүүлэг болоод Ерөнхийлөгч хориг тавихаар маш зөв зүйтэй зүйл боллоо гэж ярьж байгаа. Энэ байр суурь чинь өөрөө яг ю ямар учиртай юм бэ. Яг ямар учиртай юм. Тэгэхээр үүний цаана чинь ер нь гишүүд болоод бүлгүүд ч гэсэн хамтарсан Засгийн газрын зөв зүйтэй бодлогуудыг зөв гээд мэдээж дэмжээд явна. Буруу бодлогуудыг буруу гэдгийгээ бас хэлээд л явна. Тэгэхээр яалт ч үгүй энэ Төсвийн тогтвортой байдлын хуулийн 8 сард энэ хүрээ хязгааруудыг өөрчилсөн өөрчлөлт дээр маш их эсэргүүцэлтэйгээр энийг баталсан шүү дээ. Үүний маргааш өргөн барьсан төсөв чинь яг л ийм. Тэгээд та одоо эргээд тайлбар хэлэхдээ энэ хориг өөрөө их зөв зүйтэй гэж нөгөө талд нь 180 .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан нэмж хариулъя.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад нэмж хариулъя. Бодлогын форматын хувьд эдийн засгийнхаа өсөлтөө дэмжсэн, томоохон зорилтууддаа хүрэх ийм л хөрөнгө оруулалтын болон бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай ийм төсөв. Хэрвээ ойрын хугацаанд гарах гадаад нөхцөл байдал бид нараас шалтгаалахгүй зүйлүүд байваас зорилтдоо хүрэх энэ хурд энэ өөрөө дараагийн эрсдэлийг бий болж болзошгүй байна гэдэг дээр акцент өгсөн ийм бид хоригийг хүлээж авч байгаа. Тийм учраас энэ агуулгад тохируулж бид нар бодлогын формат руу шилжих ийм цаг хугацаа ирж байна. Энэ талаасаа бид хоригийг хүлээж авч байна гэдэг дээр би маш тодорхой, ойлгомжтой байр суурь илэрхийлсэн шүү дээ.

Алдагдалгүй төсөв батлаад ингээд нэг ийм өөрчлөлт хийсэн тохиолдолд цаашдаа мөн энийгээ бариад явахаас өөр аргагүй болно. Одоо томоохон ийм бодлогын формат руу .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Бадамдоржийн Пунсалмаа гишүүн асуулт асууна.

**Б.Пунсалмаа:** Сайн байцгаана уу. 2025 оны улсын төсөвт Ерөнхийлөгч бүхэлд нь хориг тавилаа. Үүнийг дэмжиж байгаа. Энэ жил уул уурхайн мөчлөг дагасан буюу дотоодын нийт бүтээгдэхүүн өсөлттэй байгаа. Үүнийгээ дагаад төсөв бас тэлсэн. Гэвч ийм өсөлттэй жил дээрээ төсвөө дахиад алдагдалтай батлах нь зөв үү. Төсвийн алдагдлыг заавал зээлээр санхүүжүүлдэг шүү. Тэгэхээр эдийн засаг өсөлттэй жил дээрээ бид өр нэмж үйлдвэрлэхгүй байх тал дээр хаана хаанаа анхаарах хэрэгтэй байна. Тиймээс энэ өрийг бий болгохгүй байхын тулд бид зардлаа хэмнэх хэрэгтэй гэж харж байна. Орлого бас тасарч магадгүй. Яагаад гэхээр гадаад зах зээл буюу Хятадын гангийн үйлдвэр, үл хөдлөх хөрөнгийн салбарын бууралтууд ажиглагдаж байгаа. Тиймээс орлого буурахгүй тал дээр бид нар эрсдэлийг хаах хэрэгтэй байна. Хэрвээ дунд хугацааны төсвийн тодотгол ингээд энэ орлого буурснаас болоод явагдах юм бол бид нар төсвийнхөө алдагдлыг 2 хувьтай баталсан байгаа. Тэр үед төсвийн алдагдлаа дахин нэмэгдүүлж чадахгүй

байдалд хүрнэ. Тэгээд зардлаа гаргаж чадахгүй ч гэдэг юм уу ийм олон бодит эрсдэлүүд бий болох магадлалтай байна. Иймээс тал талынхаа нөхцөл байдлыг бодолцож үзээд эдийн засаг өсөлттэй байгаа жил дээрээ төсвөө аль болох алдагдалгүй батлах тал дээр Ерөнхийлөгчийн хоригийг дэмжье гэж ийм санал оруулж байна. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баттөмөрийн Энхбаяр гишүүн асуулт асууя.

**Б.Энхбаяр:** Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хоригт 1-д улс төрийн дүгнэлт, 2-т хууль зүйн дүгнэлт өгөх учиртай. Монгол Улсын Их Хурал, Засгийн газар 2025 оны төсвийн хууль батлахдаа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригт хэлсэнчлэн хоёронтой Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлыг хөндсөн байна.

Энэ дээр 1 дүгээрт улс төр эрх зүйн дүгнэлт өгөх учиртай. Цаашид Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хурал үйл ажиллагаандаа Үндсэн хуульт ёсыг хэлбэрэлтгүй мөрдөхөд анхаарах учиртай. Бидний хамгийн дээд дарга бол Үндсэн хууль. Тийм учраас анхнаас нь жишээлбэл төсвийг алдагдалгүй оруулж ирэх, Улсын Их Хурал дээр төсвийг олон нийтийн оролцоо, санал шүүмжлэл, гишүүдийн хэлж байгаа саналуудыг тусгаж нээлттэй олон талаас нь гарч, шүүсийг нь шахах, эцэслэн батлахдаа хуульт ёсыг парламентын танхимд чанд мөрдөх гээд олон асуудлууд дээр бид дүгнэлт хийх ёстой. Энэ төсөв маань яг хууль ёсны хувьд яг батлагдсан юм уу гэдэг асуулт өнөөдөр асуулт хэвээрээ байна. Хуульд зааснаар төсөв батлах хугацаа болоогүй байсан. 11 сарын 15-наас 7 хоногийн өмнө бид төсвөө баталсан шүү дээ. Яарч. Хууль зөрчигдөх гээд байна гэсээр байгаад шахсаар байгаад баталчихсан. Бид нарт 7 хоногийн хугацаа байсан. Сайн ярилцах бололцоо, нухацтай хэлэлцэх бололцоо ийм байдалд парламент, Засгийн газар орохгүй байх, Үндсэн хуулийг зөрчин зөрчин явахгүй байх бололцоо байсан. Харин ч төрийн тэргүүн Улсын Их Хурал, Засгийн газрыг 1 талаас нь аварлаа. 1 талаас нь улс төрийн хувьд ч аварч байна. Үндсэн хууль зөрчигдөж улс төрийн хямрал үүсэхгүй байх талаас нь ч аварч байна. Тийм учраас одоо хоригийг хүлээж авсан тохиолдолд парламент энийг ямар горим дэгээр явах вэ гэдгээ парламент бас энэ алдаа дээрээ үндэслэж, тодотгосны дараа хүлээж авсантай холбоотой хэлэлцүүлгүүдээ хийх шаардлага үүсэж байна. Тэгэхгүй бол мөн эрх зүйн асуудал дахиад парламентын гишүүдийн санал шүүмжлэл, оролцоо яах вэ гэдэгтэй холбоотой асуудал үүснэ. Парламент ажлын хэсэг дангаараа гаргаад тэр хүрээндээ шийдчихвэл өөрөө төсөв зохиох эрхтэй бас байгууллага биш. Яагаад гэхээр энэ хориг хүлээж авагдсан тохиолдолд Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон өөрчлөлтөөс хойш тавигдах гэж байгаа анхны хориг хүлээж авагдсан хориг болох гээд байгаа юм. Тийм учраас энэ өөрөө Үндсэн хуульт ёс, Үндсэн хуульд оруулсан 2019 оны өөрчлөлт хэрхэн зөв амилах вэ гэдэг дээр жишиг болох гээд байгаа юм. Тийм учраас ердийн хуулийн горимоор биш, Төсвийн хуулийг олон талаас нь 4 үе шаттай хэлэлцдэг тэр горимоор. Ингэхдээ Үндсэн хуульд заасан улсын төсвийг өргөн барих эрх бол Засгийн газрын Үндсэн хуульд заасан онцгой бүрэн эрх байгаа. Энийг бас харгалзах. Энэ жин бал балансыг хадгалсан ийм дэгийг хийж байж бид хэлэлцэхгүй бол энэ цаашдын маргаан бас тасрахгүй байх шинжтэй байна.

Түрүүн Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын бас Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Ерөнхийлөгчийн хоригт заасан үндэслэл бүрэн хангагдахгүй бол дахин хориг тавихыг үгүйсгэхгүй гэдэг албан ёсны бас байр суурь илэрхийлэгдсэн. Тийм учраас энэ төрийн тэргүүний байр суурь дээр ч гэсэн парламент өөрөө их ажил хэрэгч нухацтай хандаж байж бид олон түмнээ

бухимдуулахгүй, зохиомол зөрчлүүд үүсгэхгүй, Үндсэн хуульт ёс хангагдаж ингэж цаашдаа хэвшинэ гэж ингэж үзэж байна.

**Д.Амарбаясгалан:** Баасандорж дарга 11 дүгээр микрофон асуултад хариулъя.

**Б.Баасандорж:** Баасандорж. Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Маш тодорхой асуулт асууж байна. Нэгд бол 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль хууль журмын дагуу батлагдсан уу гэж асууж байна. Тэгэхээр би Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд таны асуултад хариуцлагатайгаар хариулъя. Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт хуулийг эцэслэн батлахдаа нийт гишүүний олонх буюу 126 гишүүний 64 буюу түүнээс дээш хувиар батлах ёстой. Яг энэ Үндсэн хуулийн 6 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулиудыг яг Үндсэн хуулийн 27.6 дахь хэсэгт заасны дагуу нийт гишүүний олонх баталсан. Энэтэй та танилцах эрх бол нээлттэй байгаа. 11 сарын 8-ны өдрийн чуулганы хуралдаан, ер нь Улсын Их Хурлын чуулган, Байнгын хороодын чуулган өөрөө нээлттэй байдаг. 11 сарын 8-ны өдрийн чуулганы эхлэлээсээ авхуулаад төгсгөл хүртэл бүх чуулганы хуралдааны бичлэг бол манай веб сайт болон манай фэйсбүүк пэйж дээр танилцахад нээлттэй байгаа гэдэг зүйлийг хэлье.

2-т нь та нэг чухал зүйлийг хөндлөө. Энэ ямар дэгээр хэрвээ хоригийг хүлээгээд авбал төсвийг ямар дэгээр хэлэлцэх вэ гэдэг асуудлыг хөндлөө. Энэ бол чухал асуудал. Яг хэрвээ хоригийг хүлээж авах юм бол дэгийг энэ хоригийг хүлээж авсантай холбоотой төсвийн төслийг хэрхэн яаж хэлэлцэх тухай дэг бол яг манай өнөөдрийн Монгол Улсын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль дээр нарийвчилсан зохицуулсан зүйл байдаггүй. Яг ийм хэд хэдэн асуудлууд бол өмнө нь гарч байсан уу гэвэл гарч байсан. Жишээ нь Сонгуулийн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотой асуудлыг нарийвчилсан дэг байхгүй учраас тухайн үед Ёс зүй, дэгийн байнгын хороо хуралдаад яг энэ сонгуулийн хуультай холбоотой цэцийн дүгнэлтийг 1 удаагийн дэгээр хэлэлцэнэ гээд Их Хурлаар дэгийн тогтоол оруулаад батлуулаад, хэлэлцэж баталж байсан тохиолдол бол өмнөх парламентад ийм туршлага бол байгаа.

Тэгэхээр өөрөөр хэлбэл Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16.1-д заасны дагуу тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг энэ хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэж, саналаа нэгдсэн хуралдаанд оруулна. 16.2-т нь Ёс зүй, дэгийн байнгын хорооноос санал болгосон тухай асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална гэж заасан байгаа.

Өөрөөр хэлбэл яг одоо 4 хэлэлцүүлгээр хэлэлцэх үү, 2 хэлэлцүүлгээр хэлэлцэх үү гэсэн бид нарт ийм 2 юу байгаа. Төсвийг бол өргөн мэдүүлсэн төслийг 4 хэлэлцүүлгээр хэлэлцдэг. Хориг тавьсан төслийг ямар хэлэлцүүлгээр хэлэлцэх вэ гэдэг нарийн зохицуулалт бол Дэгийн хууль дээр байхгүй. Энд төсвийн хууль бол өөрөө ердийн хуулиас онцгой дэгээр хэлэлцдэг. Та бүхэн мэдэж байгаа. 9 дүгээр бүлгээр хэлэлцдэг. Тэгэхээр энийг бол Ёс зүй, дэгийн байнгын хороо бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлээд Их Хуралд танилцуулаад, Их Хурал олонхоороо дэг тогтоогоод явах нь хуулиараа бүрэн боломжтой гэж үзэж байна. Ерөнхий нарийн бичгийн даргын хувьд.



**Д.Амарбаясгалан:** Энхбаяр гишүүн тодруулж асууя.

**Б.Энхбаяр:** Үгүй ээ, би ч нэг их юун гуя л болоод явчихлаа л даа. Баасандорж дарга та нээлттэй байдаг, авах эрхтэй гэж үзэж байна. Улсын Их Хурлын гишүүн төрийн байгууллага албан тушаалтнаас ямар ч асуудлаар тэр байтугай улсын нууцтай холбоотой асуудлаар ч мэдээлэл авах эрхтэй байгаа.

Би 14 хоногийн өмнө баталсан гишүүдийн ирц, саналаа өгсөн байдлыг л протокол, бичлэгийг нь өгчхөөч гээд байгаа шүү дээ. Та өнгөрсөн 7 хоногийн Пүрэв гарагт бол маргааш өгнө гэж хэлж байсан. Тэр маргаашаас өнгөрөөд одоо 7 хоноод байна. Одоо 14 хоног энэ төсөв баталсан протокол, бичлэгийг өгөхгүй байгаад байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн хүсэлт гаргаад. Одоо хэзээ өгөх юм. Өгөх юм уу, өгөхгүй юм уу. Энийгээ шууд хэлчих.

**Д.Амарбаясгалан:** Баасандорж дарга хариулъя.

**Б.Баасандорж:** Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Баасандорж. Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлийг хөтлөх журам гэж байдаг. Журмын дагуу Ерөнхий нарийн бичгийн дарга үүргээ гүйцэтгэх ёстой. Журмаас давсан 1 ч үйлдэл алхам хийж болохгүй. Энэ журмыг 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 624 дүгээр захирамжаар баталсан. Өөрөөр хэлбэл 3 жил хэрэгжиж байгаа журам. Энэ журмын 2-т шинжээч буюу манай Хуралдаан зохион байгуулах хэлтсийн тэмдэглэл хөтөлдөг шинжээч маань системийн тусламжтайгаар дууны бичлэгээс, дүрс бичлэгээсээ хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлийг ажлын 5 өдрийн дотор буулгаж бэлэн болгоно. 1 дэх алхам. 2 дахь алхам нь референт буюу шинжээчийн дээд талын албан тушаалтан бэлэн болсон хуралдааны тэмдэглэлийг ажлын 3 өдрийн дотор хянана. 3 дахь алхам нь нэгжийн дарга буюу манай Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга хянасан тэмдэглэлийг ажлын 2 өдрийн дотор хянадаг. Дараагийнх нь.../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Баасандорж дарга гүйцээж хариулъя.

**Б.Баасандорж:** 4-д нь шинжээчийн хянагдсан дэлгэрэнгүй тэмдэглэлийг албажуулах Ерөнхий нарийн бичгийн даргын зохицуулалт байдаг. Яг энэ шинжээч, референт, хэлтсийн даргын системээс хянаад буулгасан тэмдэглэлийг Ерөнхий нарийн бичгийн даргад 2 өдрийн дотор хүлээлгэн өгдөг. Ерөнхий нарийн бичгийн дарга эдгээр ажлууд журамд заасны дагуу процесс явагдсаны дараа Ерөнхий нарийн бичгийн дарга гишүүн ээ албажуулдаг. Яг өнөөдрийн байдлаар Ерөнхий нарийн бичгийн даргад хандаж Энхбаяр гишүүн, Жаргалан гишүүн, Энхтүвшин гишүүн Пүрэвдаваа нарын гишүүд надад энэ тэмдэглэлтэй танилцах хүсэлтийг ирүүлсэн байгаа. Би яг энэ журамд заасны дагуу ажлын 12 хоногийн дотор нь манай холбогдох албан тушаалтнууд албажуулаад ороод ирсний дараа Ерөнхий нарийн бичгийн дарга журмын дагуу албажуулсны дараа би танд дэлгэрэнгүй тэмдэглэлийг танилцуулна. Ер нь Улсын Их Хурлын гишүүн албан бичигтэй, бичиггүй тэмдэглэл албажсан тохиолдолд танилцах эрх нээлттэй. Танилцуулах үүрэг нь надад байгаа.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**П.Сайнзориг:** Би сая Хууль зүйн байнгын хороо дээр хэлсэн үгээ л давтаж хэлье дээ. Нийт энэ улсын төсвийг 32 жилийн хугацаанд буюу 1992 оны Үндсэн хуулиас хойш 9 удаа Ерөнхийлөгч хориг тавьсан. 6 удаа дээр нь төсөв дээр бүхлээр

нь хориг тавьж байсан юм байна лээ. 2005 онд бол хоригийг хүлээж авч байсан 1 л тохиолдол байгаа. Энэ гишүүдийн тойрогтоо тавьж байсан нөгөө мөнгөтэй холбоотойгоор. Тэгэхээр ер нь бусад асуудал дээр ер нь хүлээж авдаггүй л ийм нөхцөл байдалтай явж байсан. Яах вэ энэ удаад ер нь хүлээж авах чиг байна. Тэгэхээр үүний цаана ерөнхийдөө бид нар бас энэ хэлэлцэх дэгийг ойлгомжтой болгохгүй бол ердийн хуулийн адил энэ асуудлыг хэлэлцвэл бас учир дутагдалтай. Төсвийг төлөвлөх зохиох асуудал Засгийн газрын онцгой бүрэн эрхт дээр байна. Энэ нөхцөл байдлуудыг уялдуулсан ч гэсэн бас энэ дэгийг яаралтай 1 удаагийн дэгийг маш шуурхай хийхгүй бол цаана нь бас орон нутгууд төсвөө батлах гээд хүлээгдэж байна. Энэ дээр бид бас хууль, эрх зүйн гарц гаргалгааг нь бас гаргаж өгөх зайлшгүй шаардлага бол байна гэж бас харж байгаа юм.

2 дугаарт ер нь зүгээр цаашдаа бас энэ төс хоригийг хүлээгээд аваад төсвийн хуульд холбогдох өөрчлөлтийг хийхдээ нөгөө нэг тойргийн жижиг эрх ашгууд битгий явчхаасай гэж бодож байгаа юм. 76 Сангийн сайд битгий амилаасай гэж бодож байгаа юм. Магадгүй 126 Сангийн сайд битгий амилаасай гэж бодож байна. Яг л энэ зарчим буюу шинээр хөрөнгө оруулалт тавихгүй байх энэ зарчмаа бариасай гэж би хүсэж байгаа юм.

2 дугаарт энэ хууль сахиулах байгууллага болон шүүх эрх мэдлийн байгууллага, эрүүл мэнд, боловсролын салбараас төсөв хасна гэдэг зүйлийг ерөөсөө ярьж болохгүй. Энэ хасаад байх төсөв байхгүй. Энэ жигд бас хасах тухай юм ярьж байна лээ. Болохгүй. Харин тэр хөрөнгө оруулалтын зардал болон шаардлагатай тэр урсгал зардлуудаасаа хасаж болно. Би зүгээр яах вэ олон нийтэд бас хэлсэн юм. Энэ урсгал зардлын задаргааг бид бас зөв ойлгох ёстой юм. Жишээ нь гадаад томилолтын асуудлыг хэчнээн нь төрийн өндөр албан тушаалтнуудын айлчлал байгаа юм. Хэчнээн нь бид нар гэрээ конвенцуудыг хамгаалах ажлын хэсгийг явуулах тэр зардал байгаа юм энэ тэр гээд задаргаатай ярихгүй болохоор бүгд л нэг гадаадаар зугаалах гэж байгаа юм шиг. Би ингээд ярингуут манай хэвлэлийнхэн яг дээр нь гарчгийг нь шал өөр өөрөөр өгөөд л мушгичих юм. Бид бас нөгөө иргэдийгээ, олон нийтийгээ мэдээлэлжүүлээд л нэг зөв гаргах гээд байгаа юм л даа. Тэрнээс биш энэ төсвийн мөнгөөр нэг их зугаалах гээд байгаа хүмүүс байхгүй байлгүй дээ.

Тэгээд одоо хамгийн чухал юм байна. Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө гарын үсгээ зурчихсан 2024 оны 11 сарын 19-ний өдрийн энэ албан бичгийг буюу хориг тавьсан албан бичиг барьж байна. Энэ Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоол Төсвийн тухай хуулийг баталтай холбоотойгоор ирэх жилийн 2025 оны төсвийн тухай хуулийг баталсантай холбоотойгоор холбогдох арга хэмжээ авах тухай 41 дүгээр тогтоолыг баталж байхад эсэргүүцсэн, яг энэ танхимд сууж байгаад эсэргүүцсэн 2 гишүүний 1. Номинчимэг бид 2 л болохгүй гэдэг зүйлийг ярьсан. Өөр өөрсдөө энэ хориг тавих үндэслэлүүдийг Улсын Их Хурал бүрдүүлсэн. Ажлын хэсэг бүрдүүлсэн. Ажлын хэсэг ажиллаагүй. 25-уулаа ажилласан, 70 хоног ажилласан. Тэгчхээд энэ 126 гэдэг юм уу, Засгийн газар гэдэг юм уу. Засгийн газар бол төсвөө өргөн барих эрх нь байж байгаа шүү дээ. Өргөн барьсан төсөл дээр ажиллах нь Улсын Их Хурал, тэр дундаа Улсын Их Хурлыг төлөөлж ажиллаж байгаа 25 хүний ажил. Энийгээ хийж чадаагүй байж байж нэг ийм хууль тогтсон тогтоолыг баталж Засгийн газар ч гэдэг юм уу ийм институт хоорондын үл ойлголцолыг гаргасан.

Энэ дээр Монгол Улсын Ерөнхийлөгч бүр тодорхой заасан байна шүү. Хууль дээдлэх ёсыг зөрчсөн байна. Энэ Улсын Их Хурлын тогтоол. Үндсэн хууль зөрчсөн

байна. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын тогтоолыг санаачилсан Төсвийн байнгын хороо болон холбогдох тэр ажлын хэсэг хариуцлагаа хүлээнэ биз дээ. Энд битгий төрийн энэ Улсын Их Хурлын Тамгын газарт ажиллаж байгаа жирийн албан хаагчдыг битгий хоморголоорой. Та нар л өөрсдөө оруулж ирсэн шүү. Ялангуяа тэр Төсвийн байнгын хорооны дарга орж ирээд суух ёстой шүү дээ. Та бол хамгийн түрүүнд хариуцлагаа хүлээх ёстой. Ийм институц хоорондын үл ойлголцол, энэ гишүүдийн хоосон улс төрчдийг бий болгох нөхцөлийг бүрдүүлснээрээ хариуцлага хүлээх ёстой. Тэгэхээр би эдгээр хариулт .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** 1 л зөрчилтэй юм хийчихсэн юм шиг өөрөө өөрсдийгөө бас эвгүй байдалд оруулах л зүйлсийг манай гишүүд бас их ярих юм. Өмнөх 76-г санагалзсан хүмүүсийн даалгавар ордог юм уу. Энэ 126-г бас муухай болгож харагдуулах ажил явдаг юм уу. Ийм байдлуудаас хэдүүлээ ер нь татгалзах нь зүйтэй. Яг энэ Улсын Их Хурлын баталсан тогтоолтой адилхан 2 тогтоол өмнөх юман дээр байна. Тэгэхээр энэ нэг даалгавар гүйцэтгэдэг, гар хөл болдог энэ парламентыг муухай харагдуулах гэдэг зүйл бол байж болохгүй. 3.Энхболд даргыг Их Хурлын даргаар ажиллаж байхад 2014 онд төсвөө батлангуутаа 1 дүгээр улиралд багтаж тодотгол хийх тогтоол дагаж гарсан. 2015 онд мөн адил төсвөө батлаад, 1 дүгээр улиралдаа багтааж тодотгол хийх тогтоол гарсан. Хоёулаа байж байгаа. Ер нь хууль батлагдаад хэрэгжихээс нь өмнө хуульд өөрчлөлт оруулдаг жишгүүд өмнөх парламент дээр ч байгаа. Тэгэхээр энийгээ бас зөв талаас нь харах хэрэгтэй. Сайнзориг гишүүний асуултад өөр хариулах хүн байхгүй учраас би ийм хариулт өгч байгаа юм.

Сайнзориг гишүүн тодруулъя.

**П.Сайнзориг:** Ерөнхийдөө ингээд бас нэг тодорхой байр суурь хэлэхээр хэн нэгний захиалга гэж хэлж байгаа бол бас тэгж хэлж болохгүй байх. Бид төсөв тодотгох нөхцөл байдал, үндэслэлүүдийг хуульдаа заачхаад энэ хуулиа барья. Энэ хуулиа л барья гэдгийг л бахирсан шүү дээ тэр улс төр хийгээд байгаа хүмүүс чинь. Тэгчхээд энэ хуулиасаа давсан юм баталчхаад одоо бид хэд өөр юм ярьж болохгүй. Энэ нийтээрээ бид хэд бас цаашдаа анхааръя л гэж байгаа юм. Би зүгээр энэ асуудлуудыг бас тал талаасаа бодож байгаач ээ л гэдэг зүйлийг хэлж байгаа юм. Түүнээс биш хэнийх нь зөв, хэний буруу гэдэг дээр би нэг их акцент өгмөөргүй байна. Тэгэхдээ энийг мэргэжлийн Байнгын хороо дүгнээд оруулж ирэх ёстой байхгүй юу. Ингэж хэлснийхээ төлөө би бас юу гэдэг юм таны үгнээс ч цухалзаж байх шиг байна. Хэн нэгний захиалга гэвэл би бол тийм биш ээ. Энийг бол би хариуцлагатайгаар хэлье. Энэ микрофон дээр бас тодорхой энэ хуулийг бариач ээ. Энийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг дээр хүртэл энийг дүгнэхээд байгаа шүү. Хууль зөрчсөн байна. Хууль дээдлэх ёсыг. Энэ өөрөө хориг тавьсан 1 үндэслэл нь энийг .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Зөв зөв. Санал нэг. Харин тийм ээ. Яг мэргэжлийн гишүүд, мэргэжлийн Байнгын хороод яг ийм асуудлуудыг хэлэлцэхгүй бол зарим асуудалд мэргэжлийн Байнгын хороогоор орохгүй шууд яваад байна гэдэг шүүмжлэл бас өнгөрсөн хурал дээр гарсан. Ринчендоржийн Батболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Р.Батболд:** Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе. Энэ 2025 оны төсөв бол шинээр байгуулагдсан парламентын, хамтарсан Засгийн газрын анхны төсөв байгаа. Тэгээд төсөв өргөн баригдахаас эхлээд хэлж л байсан. Энэ 118-ын бүлэг та нар их том

төсөв оруулж ирлээ. Намын дарга нар аа, энэ сонгуулийн мөрийн хөтөлбөрт байсан амлалтуудаа яг хэзээнээс эхлээд хэрэгжүүлж эхлэх гээд байгаа юм бэ. Урсгал зардлынхаа хэмжээнүүдийг багасгах нь хэзээ юм бэ гээд яриад байсан. Энэ бол нэг их тоогоогүй. Байнгын хороо дээр ч асууж л байсан. Төсвийн тэнцлээ 1 нольлоод алдагдалгүй баталчхаж, оруулаад ирчхэж болохгүй юм уу. Энийг баталж болохгүй юм уу, арга байна уу гэж байсан. Бас л олонхоороо дэмжээд л тэгээд л ямар ч өөрчлөлтгүй орж ирсэн. Тэгэхээр үүнтэй холбогдуулаад 2 л зүйлийг хэлмээр байна.

1 дүгээрт гэвэл эхлээд би Их Хурлын гишүүддээ хандаад 1 юм хэлчихмээр байгаа юм. Бид нар ард иргэдийнхээ элч төлөөлөл болж байгаагийнхаа хувьд жоохон ёс зүйтэй, зарчимтай баймаар байна. Монгол Улсын 4 жилийн хувьд ард түмний амьдрал ямар байх нь та бидний өөрсдийн итгэл, үнэмшил саналаа өгч байгаагаар л тодорхойлогдоно. Одоо энэ Ерөнхийлөгчийн хориг ороод ирсэн. Бүгдээрээ л 2 хүн энэ төсвийг нь оруулж ирээд, 1 нь оруулж ирээд Сангийн сайд нь оруулж ирээд, Төсвийн байнгын хорооны дарга нь баталчихсан юм шиг л юм яригдаад эхлэх шиг боллоо. Тэгэхээр энэ баталсан хүмүүс нэг жоохон ёс зүйтэй байсан нь дээр байх.

2 дугаарт зүгээр Засгийн газарт зүгээр санал байна. Энэ төсвийн зардлын 20 орчим хувийг юм уу, 7 их наядыг бараг төрийн албан хаагчдын цалин хөлс эзлээд байх шиг байх юм. Энэ чинь бараг 20-иод хувь байгаад байх шиг байна. Тэгэхээр энэ Засгийн газар ер нь ийм данхайсан бүтэцтэйгээ байгаад байх юм уу. Энэ зардал чинь улам ингээд нэмэгдээд байх юм уу. Энэ талаар бас жоохон хэмнэлт хийх бодлого барьж ажиллахгүй юм уу л гэж хэлмээр байна. Ийм асуудал байна.

**Д.Амарбаясгалан:** Жавхлан сайд хариулах уу. Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Гишүүний асуултад хариулъя. Урсгал зардлын ер нь 70 хувийг 3 салбар байгаа юм. 3 төсвийн ерөнхийлөн захирагч гэсэн үг. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн яам. Энэ 3 салбар дээр гэсэн үг. Ингээд нийтдээ төрийн албан хаагч нарын мөн л 60-70 хувь нь энэ 3 салбар дээр байдаг гэсэн үг. Тэгэхээр бид алдагдалгүй төсөв батлахын тулд ер нь дор хаяж 2,2-3 их наяд төгрөгийн зардал, орлогын асуудал яригдана. Тэгэхээр мэдээж энэ 3 салбарын урсгал зардал хүрэхгүйгээр ийм хэмжээний бид нар үйл ажиллагааны таналт хийх ямар ч боломж байхгүй. Тэгэхээр орж л таарна. Тэгэхээр өөрөөр хэлбэл одоо бол тийм хэмнэлт гэдэг ойлголт байхгүй. Төлөвлөсөн үйл ажиллагаануудыгаа татна гэсэн үг. Өөрөөр хэлбэл урсгал зардлын 1 төгрөг болгоны цаана Засгийн газрын үйл ажиллагаа байдаг. Тийм учраас мөн л төрийн албан хаагч нарын энэ бүтэц, цалин хөлс рүү ч гэсэн тодорхой хэмжээгээр бид урсгал зардлаа танах, алдагдалгүй төсөвтөө цаашдаа явах ийм том бодлогын шилжилт хийж байгаатай зэрэгцээд энэ ажлуудаа бол шат дараатай давах зайлшгүй шаардлага гарна. Яг одоогоор бол тийм тодорхой тооцоолол хэлэхэд бол арай эрт байна.

**Д.Амарбаясгалан:** Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Л.Мөнхбаясгалан:** 126-уулаа нийлээд төсөв баталсан. Хүлээх ёстой хариуцлага байвал хүлээх цаг ирсэн юм шиг байна. Монгол Улсын Их Хурлын гишүүн бид Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөсөн. Тангаргаа зөрчсөн бол, хэрвээ үнэхээр алдаа хийсэн бол тэрийгээ залруулах ёстой байх. Ерөнхийлөгчийн

хоригийг хүлээн авах талд байр суурьтай байгаа. Харин батлах явцад нэг сонин үйл явдал гарсан. Тойргоос сонгогдсон гишүүд 5, 5 тэрбум төгрөгийн авлига авах гэж байна. Тойрогтоо тавиулж, хувьдаа завших гэж байна гээд. Энэ нь бүр серьёзны болоод манай зарим гишүүд энэ 5, 5 тэрбумын хулгайч нартай байлдаж хэвлэл мэдээлэлд ярилцлага өгч эхэлсэн. Би тойргоос сонгогдсон гишүүн. 5 тэрбум төгрөгийн хулгай хаана явагдсаныг ерөөсөө мэдэхгүй юм. Ажлын хэсэгт байсан. Байнгын хороод дээр байсан. Хаагуур нь тийм 5 тэрбумын хулгайд бид оролцсон юм бол. Одоо энэ нэр төрөө бас цэвэрлэж авмаар байна. Говийн бүсийн 7 дугаар тойргоос сонгогдсон гишүүний хувьд тойргийн сонгогчид доо хариуцлагатайгаар хэлэхэд 5 тэрбумын хулгайд лав оролцоогүй. Би лав тийм хулгай олж сонсоогүй. Энд гэхдээ бүр эрх мэдэл бүхий албан тушаалтнууд телевизээр энд тэнд хэлэлцүүлэгт очоод ярьсан байгаа шүү. Энийг бас тодруулж, хэрвээ ийм 5, 5 тэрбум төгрөг нэхсэн тохиолдол байвал Жавхлан сайд тэрийг нь хэлээд өгөөч.

Занданшатар даргаас 1 юм асууя. Их Хурал хоригийг хүлээж аваад, 1,9 их наядаар хэрвээ алдагдлыг бууруулж чадахгүй бол дахин хориг тавих боломж байгаа юу. Тийм хууль, эрх зүйн орчин бий юу.

2 дугаар асуулт нь хэнээс асуух юм. Засгийн газар дахиж төсвөө задалж оруулж ирэх юм уу, Улсын Их Хурал дээр 2 дугаар хэлэлцүүлгээр ажлын хэсэг байгуулаад явах юм уу.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Занданшатар даргын микрофоныг өгье. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

**Г.Занданшатар:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Дэлхий дээр тэмцлийн дүрэм нь алдагдалгүй төсөв баталдаг тийм тэмцлийн дүрэмтэй улсууд байна. Эдийн засгийн нөхцөл байдлаасаа шалтгаалж манайх шиг уул уурхайн эдийн засагтай мөчлөг дагаж төсвийн хүндрэл бий болдог ийм улсууд дээр энэ цаг үед алдагдалгүй төсөв батлах шаардлагатай гэж Монгол Улсын Ерөнхийлөгч үзсэн. Алдагдалгүй төсөв батлах нь улс орны болон нийт иргэний эрх ашигт бүрнээ нийцнэ гэж үзэж байгаа. Гадаад төлөв байдал, болзошгүй эрсдэл. 9 сард төсөв өргөн барьснаас чинь хойш хүртэл дэлхийн нөхцөл байдал яаж өөрчлөгдөж байна. Гадаад зах зээл яаж өөрчлөгдөж байна. Ийм учраас алдагдалгүй төсөв батлах шаардлагатай гэж үзэж байгаа. Ерөнхийлөгчийн тавьсан шаардлага хэрвээ хангагдахгүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч дахин хориг тавихыг үгүйсгэхгүй. Хууль, эрх зүйн хувьд бол ийм бололцоотой.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Тэгээд товчхондоо бол тийм зүйл огт болоогүй. Одоо гишүүд, тойргийн гишүүд ялангуяа Засгийн газарт шаардлага тавиад, тойргууд дээр төсөв тавь. Тийм хэмжээний хөрөнгө оруулалтуудыг тавь гэдэг тийм биднээс шаардсан, нэхсэн зүйл огтоос болоогүй шүү. Ер нь бол яах вэ өмнө нь бид чинь 76 гишүүд, Их Хурал тойргийн дан гишүүд маань өөрсдөө бас л том үүрэгтэй шүү дээ. Тойрог дээр хөрөнгө оруулалт татах, тэнд бүтээн байгуулалт хийх тэр ард түмэн нь хүлээгээд байж байдаг. Амласан зүйлүүд байж байдаг. Том орон нутгийн хөгжлийн зорилтууд ч бас байна. Тэгээд гишүүдийн оролцоотойгоор тэднээс санал авч, зовлон жаргал тэр орон нутгийнхаа бүх зүйлийг мэддэгийн хувьд тэндээс санал авч, энэ хөрөнгө оруулалтуудын бодлогод тусгаж явж ирсэн зүйлүүд бол их олон жил үргэлжилсэн л ийм л зүйлүүд



шүү дээ. Тэгээд тэр хандлага л орж ирсэн ийм хэлэлцүүлэг болсон байх гэж харж байгаа. Тэрнээс биш тэнд бол ямар нэг тийм .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

**Л.Мөнхбаясгалан:** Тэгэхээр Улсын Их Хуралд хулгай байдаг бол хулгайг нь илрүүлэх гэж, хулгайч нар байдаг бол хулгайч нартай нь тэмцэх гэж орж ирсэн болохоос хулгай хийгээгүй ээ. Хийх гэж орж ирээгүй. Хийгээ ч үгүй гэдгээ Сангийн сайд Жавхлангийн үгээр нотоллоо. Тойргийнхондоо хандаж хэлье.

**Д.Амарбаясгалан:** Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ө.Шижир:** Өдрийн мэнд. 2025 оны улсын төсөв хэлэлцэж байх үед Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс 3 дүгнэлт гаргаж байсан. Мөн манай Ардчилсан намын бүлгээс 10 сарын 31-нд Төсвийн байнгын хороо дээр 4 заалттай бас санал, дүгнэлтээ хүргүүлж байсан. Тэгээд яг энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Ардчилсан намын дүгнэлттэй холбоотой энэ 5, 6 заалтаас аль нь ч хэрэгжээгүй л дээ. Тэгэхээр Төсвийн тогтвортой байдлын зөвлөл гэдэг зөвлөлийг бид нар тэнд зүгээр хэдэн хүн суугаад цаас хийдэг, тэрийг нь Их Хурал хүлээж авдаггүй. Төсөв боловсруулахдаа хүлээж авдаггүй юм бол энэ зөвлөлийг дахиж нэг эргэж харах хэрэгтэй. Ер нь бол Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, парламентад суудалтай улс төрийн намуудын санал, дүгнэлтүүдийг ажил хэрэг болгоод хүлээж авдаг байх нь бол ер нь бол улс төрийн соёл шүү дээ. Ерөөсөө огт тийм юм байхгүй. Тэгээд 1992 оноос хойш Улсын Их Хурал болсноос хойш Засгийн газраас өргөн барьсан улсын төсөв түүхэндээ анх удаагаа өргөн барьснаараа батлагдсан. Их Хурлаас 25 хүнтэй ажлын хэсэг байгуулагдсан. Тэр дээр ямар нэгэн дорвитой шийдэл бас гаргаагүй. Яг анхны төслөөрөө батлагдсан. Одоогоос 10 жилийн өмнө Монгол Улсын урсгал зардал, улсын төсвийн урсгал зардал өөрөө 6 тэрбум байсан бол одоо 5,5 дахин өссөн. 2025 оны улсын төсөв дээр зэсийг 7491 доллар, нүүрсийг 129 доллароор тооцсон. Валютын ханшийг 3380 доллароор тооцсон. Улсын төсөв батлагдсанаас хойш зэс 15 доллароор, нүүрс 10 доллароор унасан. Валютын ханш өссөн. Албан бус ханшаар 30 төгрөгөөр өссөн, албан ханшаар 8 төгрөгөөр өссөн. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьж байгаа энэ хориг дээр яг энэ асуудлуудыг дурдчихаад байгаа байхгүй юу. Олон улсын нөхцөл байдал, гадаад, нөхцөо байдлууд, бид нарын зарж борлуулж амьдардаг хэд хэдэн бүтээгдэхүүний үнийн өсөлт, хэлбэлзэл гээд.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах нь зүйтэй. Ер нь бид цаашдаа улсын төсөв батлахдаа парламентынх нь вебсайт дээр тавьж хэлэлцүүлсэн байдалтай болоод өнгөрдөг биш, олон талын хэлэлцүүлэг явуулдаг хэрэгтэй байх хэрэгтэй байна. 1 дүгээр хэлэлцүүлэг дээр миний бие хэлж байсан. 2024 оны 8 сард улсын төсөв тодотгосноос хойш 2025 оны төсөв дээр шилжиж орж ирж байгаа 140 төсөл байна. Энэ 140 төсөл хамгийн багадаа 18,6 хувь, хамгийн ихдээ 725 хувиар анхны төсөвт өртөгөөсөө нэмэгджээ. Энэ 140 төсөл хөтөлбөрийн төсөвт өртөг нь анхны өртөгөөсөө нэмэгдсэн. Нийт өртөг нь 1 их наяд, ойролцоогоор 1 их наяд төгрөг байна. Энэ төсөвт өртгүүдээ эргэж хараач ээ. Яагаад ингээд тодотгол дээр ч өсөөд, төсөв дээр ч өсөөд, хамгийн багадаа 3 жил, хамгийн ихдээ 14, 15 жил зарцуулдаг юм бэ. Энэ өөрөө яг одоо бид нарын яриад байгаа улсын төсвийн урсгал зардлын чинь нэмэгдэл байхгүй юу. Ингээд л бид нар жил болгон нэмээд байдаг. Тэгэхээр ер нь бид нар цаашдаа бас ялангуяа энэ Улсын Их Хурлаас

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдаж байгаа ажлын хэсэг ажил хэрэгч байдаг баймаар байна. 25 хүнтэй. Тэгээд тэндээс нь ямар санал гарсан нь тодорхойгүй. Байнгын хороо дээр л хэдэн зарчмын зөрөөтэй санал гардаг. Төсөв дээр өөрчлөлт байхгүй. Ингээд яваад байдаг бол бид нар бас төсөв дээр ажлын хэсэг байгуулах шаардлага ер нь байгаа юм уу. Эсвэл сонгогдсон гишүүд маань ажил хэрэгч байдлаар хандаач. Тэгэхгүй бол ингээд Амарбаясгалан даргын хэлж байгаатай 100 хувь санал 1 байгаа. Нэг их муухай 126 хүн суучаад л хамаг муухай төсвийг батлаад байгаа юм шиг. Энэ чинь ажлын хэсэг дээр боогдож бас орж ирэх ёстой шүү дээ. Тэгэхээр үүн дээр бас цаашдаа хэдүүлээ анхааря гэдэг саналтай байна.

Ер нь бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг бол хүлээж авах нь зүйтэй. Нийтдээ түрүүн Сайнзориг гишүүн хэлж байна лээ. 9 удаа хориг тавьж байсан юм байна. Монгол Улсын төсөв нийтдээ 5 удаа тухайн батлагдсан төсөв бол ашигтай тайлан тоондоо ашигтай гарч байсан юм байна. Тэгэхээр 2025 оны төсвөө хэдүүлээ урсгал зардлыг нь тэнцүүлээд, тэгээд 2025 ондоо тайлан тоондоо ашигтай гардаг тийм төсөвтэй больё.

**Д.Амарбаясгалан:** Үндсэндээ үг хэлчихлээ дээ тийм ээ. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**С.Эрдэнэбат:** Төсвийн тодотголтой холбоотойгоор сая өмнөх гишүүдийн асуулт дээр боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж гээд цалин хөлс рүүгээ хүртэл оргоно гэдэг байдлаар, орохоос аргагүй ээ гэдэг ийм байр суурь хэлчих шиг боллоо. Тэгэхээр миний хувьд өмнө ч бас төсвөөр, төсвийн тодотголоор бас зарим багтаагүй юмнуудаа эргэж ярина гэдэг байдлаар тухайлбал манай улсын хамгийн доод цалин буюу суурь цалин маань 100 хэдхэн доллар байгаа л даа. Тэгээд энийгээ ирэх 4 сарын 1-ээс иртэл мөрдөх ёстой энэ тэр гээд. Гэтэл дахиад энэ цалингийн нэмэгдэл бол зүгээр нэг инфляцаа хаах хэмжээний л төдийгийн нэмэгдэл байгаа шүү дээ 6 хувь гээд. Тэгэхээр ийм юм руугаа орно гэдэг бол бас л хэцүү сонсогдож байна. Миний хувьд бол битгий ингээсэй гэж бодож байна. Мөн дээрээс нь урсгал зардал дотор бас маш чухал зардлууд бас байна лээ. Бүгдээрээ гадаад, дотоод ч гэдэг юм уу, тавилга эд хогшил гэдэг байдлаараа бид нар олон нийтэд бас ойлгуулчихсан. Дотор нь маш олон хууль дагаад орж ирэх ёстой. Хүүхдүүдэд зориулагдах, ажилчдад зориулагдах Засгийн газрын бас чухал зайлшгүй хийдэг энэ зардлууд дотор бол бас байна лээ. Хасах зардлууд бас байна лээ. Бид энэ талаар бол нэмэлт тодруулга бол авъя гээд өгсөн байгаа.

Тийм учраас энэ тал дээр бас Засгийн газар маань төсвийн Ерөнхийлөгчийн хоригтой холбоотойгоор дахиж төсвөө оруулж ирэхдээ бас хаанаас нь танах вэ, яах вэ гэдгээ бас маш сайн зөвшилцөж ярих шаардлагатай. Манай улс маань энэ цалин хөлс, нийгмийн хамгааллын хувьд бол тийм сайн болчихсон зүйл ерөөсөө байхгүй. Харин ч бид нар сонгуулийнхаа мөрийн хөтөлбөрийн амлалтыг биелүүлье гэдэг ийм зүйлийг бас энэ хориг дотор тусгасан байна. Жил болгон үнэ инфляцын өсөлттэй уялдуулаад цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжээ нэмнэ гээд маш том хүлээлттэй байгаа. Гэхдээ төсвийн бас анхны жил учраас дуусгаагүй барилгуудаа дуусгая. Зарим томоохон эрчим хүч, бүтээн байгуулалттай холбоотой төслүүдээ урагшлуулъя гэдэг л үндсэн зарчмыг бол уг нь анх ярьсан. Явцын дунд бол яах вэ тэгээд янз бүрийн тойргийн хүсэл саналуудтай холбоотойгоор бол зардлууд орж ирээд үндсэн зарчим алдагдахаар бас энэ хооронд бас үл ойлголцох байдал ч бас зарим талаар үүсгэсэн. Тийм учраас бол зардлыг эрх ашгийнх нь хувьд болон ач холбогдлын хувьд нь бол

эрэмбэлэхдээ ажлын хэсгээс гадна гишүүдийнхээ бас оролцох оролцоотой холбоотойгоор бас илүү нягт нямбай бас ажиллах бол бас шаардлага байна гэдгийг бол хэлмээр байна.

Тэгээд дараагийн нэг асуулт нь нэгэнт ирэх оны төсвийн тодотгол дахиж хийгдэх үү. Одоо энэ хоригтой холбоотойгоор засвар юунуудыг бол нэг мөр хийе гэдэг байдлаар би ойлгож байна. Ирэх онд хийгдэхгүй бол Ёс зүй, дэгийн байнгын хороогоор 1 удаагийн дэгээр хэлэлцэхэд бол магадгүй дахиад дутуудуулчих вий. Яарч байна гэдэг байдлаар оруулчих вий. Тийм учраас яг ямар дэгээр хийхдээ жоохон боломж олгоод, дахиад бас сайн ярих ийм дэгийг батлах нь бол зөв байх гэж би бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулъя.

**Б.Жавхлан:** Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Тийм ээ. Би тантай санал нийлж байна. Ер нь тодотголоор ч тэр төрийн тэргүүний тавьсан хоригийн хүрээнд ч тэр хөндөж болохгүй суурь 3 нийгмийн зардал байгаа юм. Хүүхдийн мөнгө, тэтгэвэр тэтгэмж, 3-д нь нэг ч төрийн албан хаагчийн цалин шүү. Би түрүүн дутуу хэлчихлээ. Уучлаарай. Тэр цалин гэж байгаа нь цалингийн санг ярьж байгаа юм шүү Эрдэнэбат гишүүн ээ. Тэр 7 их наяд чинь цалингийн нийт сан байхгүй юу. Тэгэхээр цалингийн нийт сан дээр өөрчлөлт гарна гэдэг маань нэгж цалин дээр өөрчлөлт оруулахгүйгээр бүтэц, орон тоо ийм зохион байгуулалтын асуудал руугаа л шилжинэ гэсэн үг. Тэрнээс ер нь бол ялгаатай юм байгаа юм шүү.

Тодотголын хувьд ч тэр, хоригийн хувьд ч тэр тавьж байгаа шаардлага, үзэл баримтлал, агуулга бол 1 байгаа учраас ингээд одоо бид хоригоо ярьж эхэлж байгаа учраас үүгээрээ явах нь зүйтэй болов уу гэсэн зүгээр миний гишүүн хүний санал энэ байна шүү.

Дээрээс нь яг төсөв хэлэлцэх үед Төсвийн байнгын хороо дээр яг тэр хамгийн сүүлийн Байнгын хороо дээр би саналаа маш ойлгомжтой хэлж байсан. 1 дүгээр хууль улиралд багтаана энэ тодотгол гэдэг асуудал яригдсан. Би тэнд юу гэж хэлсэн бэ гэхээр 1 дүгээр улирал гээд ингээд хойшлуулчихаар бүтэн 4 сар хүртэл Монгол Улс төсөвтэй ч юм шиг, төсөвгүй ч юм шиг маш тодорхойгүй байдал үүсэж явах нь. Тийм учраас энэ бол маш тийм хүндрэл үүсгэнэ. Тийм учраас болдог бол ондоо багтаагаад энийгээ нэг тийш нь болгоод, нэг мөр тодорхой болгочих нь зүйтэй. Тийм учраас болдог бол хууль журмынхаа хүрээнд 12 сардаа багтаагаад отодотгол хийе гэдэг ийм саналыг би маш ойлгомжтой хэлсэн байгаа. Тэгэхдээ одоо бол Их Хурал дээрээ л шийднэ шүү дээ. Одоо хоригийн хүрээнд хөрөнгө оруулалт, зардал энэ бүх юмнуудаа яаж үйл ажиллагааны айхтар том доголдол үүсгэхгүйгээр, мөн эдийн засгийнхаа өсөлтийг мөн хадгалаад, хөгжлийнхөө зорилтуудад хүрэх, зорилтоо хадгалаад ингээд ямар нэг гаднаас том шок эрсдэл гарах юм бол тэрийгээ зөөлрүүлээд ингээд явах л төсвийн орчин бий болгоё гэж байгаа дээр бол санал нийлж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Өнөөдөр хуралдсан Байнгын хороод ер нь гишүүдийн дийлэнх нь ер нь хоригоо хүлээж авах нь зүйтэй гэсэн ийм байр суурийг бас илэрхийлсэн байна лээ. Харин зүгээр энд бас гишүүдийн ярьж байгаа нэг зүйлийг бид яаж зохицуулалт хийх юм. Яг хориг гээд хүлээж аваад хэлэлцэх юм бол 2 шатын хэлэлцүүлэг хэлэлцээд батлаад явах нөхцөл байх юм. Зарим гишүүдийн гаргаж байгаагаар бүр Засгийн газарт буцаагаад, дахиж өргөн барих процесс гэхээр Дэгийн



тухай хуулиар зохицуулалт байхгүй. Нөхцөл байдал хүндэрчхэж байгаа юм. Агуулга нь болохоороо Засгийн газрын өргөн барьсан төсөвт хориг тавьж байгаа биш, Улсын Их Хурлаар хэлэлцээд баталсан төсөвт хориг тавьж байгаа ийм нюанстай зүйлүүд байгаа. Гишүүд маань энэ дээр их сайн бодолцож бүгдээрээ бас Ёс зүй, дэгийн байнгын хороо, холбогдох нөхдүүд бас хуралдаж гарц гаргалгаа гаргах нь зөв болов уу гэсэн ийм байр суурь байгаа гэдгийг бас хэлье. Жудагийн Баярмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Баярмаа:** Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд 1 талаасаа яалт ч байхгүй Их Хурлын гишүүд бид нарын хариуцлагын асуудал бас яригдана л даа. Арга байхгүй бид нар л баталсан. Тэгээд уг нь бол хасъя, таная гэсэн зардал дэмжигдэхээр дахиж байгаад л бараг унагааж байсан. Тэрийгээ санах хэрэгтэй. Түүнээс биш бүр зориуд хэлье. Гэнэтхэн үсэрч гарч ирээд л хэдэн нөхдүүд попроод гээд л маш олон хүний амнаас гарч байгаа. Тийм юм байхгүйгээ бас санах хэрэгтэй гэдгийг бас зориуд хэлмээр байна.

Тэгээд энэ дэгтэй холбоотой асуудлаар би зориуд Баасандорж даргаас асуумаар байгаа юм. Сая бас яг Амарбаясгалан дарга хэлж байна л даа. Би бас энийг хэлж л байсан өмнө нь удаа дараа. Бүр өөрт нь хүртэл хэлж байсан. 73.4-өөр байж байгаа шүү дээ. Одоо энэ төсөвтэй холбоотой зохицуулаагүй асуудлыг Дэгийн тухай хуулиар зохицуулна гээд. Тэгэхээр энэ төсөвтэй холбоотой асуудал чинь яаж зохицуулагдах юм бэ. Тусгай гэж авч үзээд шинээр юм зохиох юм уу, эсвэл бол энэ ердийн хуультай адилхан Ерөнхийлөгчийн хоригийг авах зүйл заалт гээд ингээд заачихсан байгаад байгаа юм. Энийгээ барих юм уу гээд. Одоо Ерөнхийлөгчийн хоригийг яаж авах вэ гэхрээ энэ чинь 90.9 дээр жишээ нь байж байгаа байхгүй юу. Холбогдох Байнгын хороо нь аваад, цаашаа үргэлжлүүлээд шийдвэрээ оруулж ирнэ гээд ердийн хуулиар явуулбал. Үгүй ээ, энэ бол тусгай хууль гээд та дандаа тэгж хэлж байсан. Тэрүүгээр явах юм бол зохицуулалт байхгүй. Зохицуулалт байхгүй юм Монгол Улсад байхгүй шүү дээ. Эрх биш энэ Монгол Улс чинь бас нэг хуультай улс. Би бас зөндөө хэлж байсан. Дэгийн тухай хуулийн 3.2-оор Улсын Их Хурал бүрэн эрх нь байгаа. Энэ зохицуулаагүй зүйлээ гялс зохицуулсан нэмэлт оруулаад тэгээд шийдье гээд зөндөө хэлсэн. Бид нар угаасаа хугацаандаа амжаагүй зүйлээ тэгээд л нэмэлт оруулаад л сая 9 сард тэр нөгөө 2025 оны хөгжлийн төлөвлөгөөг баталсан шүү дээ. Тэгэхээр ингээд яг хэрэгтэй үедээ 1 заалтыг нь ашиглаад л, хэрэггүй үедээ ингээд л ашиглахгүй янз бүрийн байдлаар хуульд хандаад, хуулийг янз бүрээр тайлбарлаад баймааргүй байна.

Түрүүн Амарбаясгалан дарга бас зөв л хэлсэн л дээ. Уг нь бол 1 дүгээр улиралд багтаагаад гээд нэг төсөл явж байсан. Бид нартай бас уулзсан. Тэгээд яах вэ дэмжээ ч үгүй дэмжсэн ч биш тэгсхийгээд л өнгөрөөсөн. Тэгээд сүүлдээ ондоо багтаагаад болоод ирсэн. Тэгээд ондоо багтаана гэхээр магадгүй яг энэ сая Ерөнхийлөгчийн хориг дотор ороод ирж байгаа байхгүй юу. Хуулийн зөрчил гээд. Тэгэхээр Тамгын газар энэ хууль тайлбарлах асуудал дээрээ толгой эргүүлээд, буруу зөрүү явснаас бас асуудал үүссэн гэж би бодож байгаа юм.

Хоригтой холбоотой нэг зүйл дээр санаа зовж байна л даа. Алдагдалгүй төсөв гээд их яриад байна. Тэгэхээр алдагдалгүй байх нь гол биш, миний бодлоор бол үр ашиггүй бүх зардал нь танагдах нь өөрөө гол. Тэгэхгүй бол ерөөсөө алдагдалгүй баталдаг гэдэг нэг ийм жишиг тогтоож аваад л, тэгээд орлогоо бол бас хэд ч гэж тавьж байгаад л түүндээ нийцүүлээд оруулаад ирээд байхыг үгүйсгэхгүй гэж. Би бол .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** 1 минут нэмж өгье. Баярмаа гишүүнд.

**Ж.Баярмаа:** Тэгэхээр ерөөсөө төсвийн чинь үндсэн 4, 5 зарчим байгаа шүү дээ. Хамгийн чухал зарчим бол үр ашигтай байх л гээд байгаа шүү дээ. Хамгийн гол зарчим ердөө л энэ. Тэгэхээр ямар ч үр ашиггүй, ямар ч хэрэггүй зардлуудаа л хасах нь л хамгийн чухал болохоос биш, зүгээр нэг алдагдалгүй гэдэг рүү битгий бас шуураач гэж хүсмээр байна. Тэгээд энэ дээр бол зөвхөн урсгал зардал гэхээр мэдээж энэ цалин хөлсийг бол хасаж болохгүй. Эрүүл мэнд, боловсрол. Гэхдээ хөрөнгө оруулалтад бас хэрэггүй зардал байгаа шүү дээ. Нөгөө 13 тэрбум төгрөгийн дипломат корпус, нөгөө Тэрэлж рүү татсан зам. Тэгээд энэ хуулиа баримаар байна. Зураг төсөвгүй, магадлалд ороогүй 13, 14 төсөл байгаа гээд би бүр анхнаасаа л ярьсан. Энийгээ бүгдийг нь бас хасах хэрэгтэй. Бүх юмаа хуулийн дагуу гоё цэвэрхэн болгож энэ дараагийн төсөв нь орж ирээсэй гэж хүсэж байна. Хуулийн зөрчилтэй 1 ч төсөв, арга хэмжээ байж болохгүй. Дээрээс нь тэр үргүй буюу хөрөнгө оруулалтын шинжтэй тэр барилга байгууламж, мэдээж энэ чинь эргээд мөнгө болохгүй нь тодорхой шүү дээ. Түүнээс биш хөрөнгө оруулалтаас хасах гэлээ гээд бас битгий .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Үндсэндээ үг хэлчихлээ. Тийм ээ, Баярмаа гишүүн. Баасандорж дарга. Хуулийн тайлбар 73.4-ийг.

**Б.Баасандорж:** Баярмаа гишүүний асуултад хариулъя. Баасандорж. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга бол Баярмаа гишүүн ээ, хууль тайлбарлах эрх байхгүй. Би бол хууль тайлбарлаагүй шүү. Би та бүхэнд зөвлөх үүрэгтэй. Тэгээд гишүүд маань олонхоороо шийдвэрлэдэг. Тэгэхээр би зөвлөж байгаа шүү. Яг хуулийн, дэгийн талаас нь. Та сая Дэгийн тухай хуулийн 73.4-ийг асуулаа. 73.4 дээр “төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй холбоотой энэ бүлгээр зохицуулаагүй бусад асуудлыг энэ хуульд заасан хууль тогтоолын төслийг хэлэлцэх журмын дагуу баримтална.” гэж байгаа. Өөрөөр хэлбэл энэ асуудал дээр 1 дэх хэлэлцүүлгийг яаж хийх вэ, 2 дахь хэлэлцүүлгийг яаж хийх вэ, 3 дахийг яаж хийх вэ, 4 дэхийг нь бүгдийг нь зохицуулчихсан байгаа. Зохицуулаагүй жишээ нь үг хэлэх, асуулт асуух, горимын санал гаргах энэ зүйлүүдийг яг 69, 70, 71, 72 дугаар зүйлээр гишүүн ээ зохицуулаагүй байхгүй юу. Тэгэхээр энэ зохицуулаагүй үг хэлэхтэй холбоотой, асуулт асуухтай холбоотой асуудлыг энэ хуульд заасан журмын дагуу зохицуулсан шүү гэж хэлж байгаа юм.

2 дахь таны асуулт бол таны яг энэ асуулт бол 3 дугаар хэлэлцүүлэгтэй холбоотой асууж байна. Яг энэ зүйл буюу 9 дүгээр бүлэг дээр 1 дүгээр хэлэлцүүлэг дээр ямар зүйлийг зохицуулах юм, 2 дугаар хэлэлцүүлэг дээр ямар зүйлийг зохицуулах юм гэдгийг маш нарийн зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл таны асуусан 1, 2 дугаар хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй санал гаргах нь 126 гишүүн дээр нээлттэй. 3, 4 дүгээр хэлэлцүүлэг дээр ямар ч санал хураалт зарчмын зөрүүтэй санал гаргаад, тэрийг нь санал хураах нь гишүүн ээ энэ дэгийн хуулиар хориотой байхгүй юу. Зөвхөн хуулийг зүйл заалт бүрээр нь уншиж, батлах зүйл л 4 дүгээр хэлэлцүүлэг дээр байдаг. Тэгэхээр гишүүдээс маань гарсан энэ санал 3 дугаар хэлэлцүүлэг дээр гарсан учраас буцаах болон зарчмын зөрүүтэй санал гаргаж хураах асуудал дэгийн хуулиараа хориотой учраас энэ 73.4 хэрэглэж болохгүй ээ, боломжгүй ээ, буцаах асуудал байхгүй. Буцаах асуудал зөвхөн 1 дэх хэлэлцүүлэг дээр 126 гишүүнд маань байсан шүү гэдгийг би өмнөх төсвийн хуулийг хэлэлцэн батлахад ч мөн хэлж байсан. Одоо бас дахин мөн танд зөвлөө гэдгийг хэлье.

**Д.Амарбаясгалан:** Баярмаа гишүүн тодруулж асууя.

**Ж.Баярмаа:** Тэгээд одоо яг яах билээ. Түрүүн зөндөө хүмүүс асуусан. Та ерөөсөө хариулахгүй байна. Тусгай зохицуулалт гэж үзээд, шинээр дэгийн тухай хуулиараа нэмэлт, өөрчлөлт оруулаад явах юм уу. Би бас яг танд хэлж байсан. Ингээд явж болно шүү дээ гээд. Тэгж явах юм уу, эсвэл бол энэ 90.9-ийг баримтлаад шууд 2 дугаар хэлэлцүүлгээсээ эхлэх юм уу. Энийг та тодорхой хариулаад өгөөч.

**Д.Амарбаясгалан:** Баасандорж дарга нэмж хариулъя.

**Б.Баасандорж:** Би тодорхой хариулъя. Төсвийн төслийг хэлэлцэхтэй холбоотой 9 дүгээр бүлэг дээр зохицуулсан тодорхой 2 асуудал байгаа. Улсын жилийн төсвийн төслийг болон мөн 73.3-д заасан төсвийн тодотгол өргөн мэдүүлбэл яаж хэлэлцэх вэ гэдгийг нь маш тодорхой заачихсан байгаа. Одоо бид нар Ерөнхийлөгчийн хоригийг ярьж байгаа. Хоригийг хэрвээ хүлээж авсан нөхцөлд яг ийм, ийм дэгээр ингэж, ингэж зохицуулна гэсэн нарийвчилсан зохицуулалт Баярмаа гишүүн ээ, энэ дэг дээр байхгүй. Энэ дэг дээр буюу чуулганы хуралдааны дэгийн хууль дээр харин 16 дугаар зүйл хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх журам гэж байгаа. Өөрөөр хэлбэл Ёс зүй, дэгийн байнгын хороо яг энэ чуулганы хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг буюу хоригийг хүлээж авсантай холбоотой хэлэлцэх дэгийг төсвийг боловсруулах дэгийг энэ Байнгын хороо маань боловсруулаад Их Хурлын чуулганы хуралдаанаар тогтоолын төслийг оруулаад, хэрвээ гишүүд маань хүлээн зөвшөөрөөд батлах юм бол тэр дэгээр явна.

**Д.Амарбаясгалан:** Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн дараалалд. Миний энэ дэлгэц дээр байхгүй байх юм. Бадамсүрэн гишүүний микрофон.

**М.Бадасүрэн:** Цаашид алдаагүй хууль, сайн төсөв батлах энэ зүйл дээр том сургамж болж байна даа гэж үзэж байна. Ерөнхийлөгчийн хоригт ингэж бичсэн байгаа юм. Ард иргэд, баялаг бүтээгч, татвар төлөгчид болон мэргэжлийн байгууллагуудын зүгээс төсвийн сахилга батыг чангатгах, үр ашигтай хэмнэлттэй байх зарчимд нийцүүлэн 1 дүгээрт төсвийн алдагдлыг бууруулах, зардлыг бууруулах, 2-т чиг үүргийн давхардлыг арилгах, 3-д нь улс төрийн нам эвслүүд сонгуулийн амлалтаа биелүүлэх зэрэг санал шүүмжлэлийг хэлж байгаа нь зүй ёсны шаардлага гэж үзэж байна гээд.

Тэгэхээр сонгуулийн амлалт буюу мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхтэй холбоотой зүйл дээр ухралт хийхгүй байх энэ зүйлийг мөрдөж ажиллах гэдэг зүйл цаашдаа бол бидэнд ус агаар мэт бол хэрэгтэй болно гэж үзэж байгаа. Тэгээд би энэ дээр ганцхан жишээ хэлье. Сонгуулийн мөрийн хөтөлбөрүүдэд ЖДҮ-лэл, ялангуяа бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийг дэмжсэн ийм хөнгөлөлттэй зээлийн бодлогыг хэрэгжүүлнэ гэж маш их дэвшүүлсэн. Сонгуулиар энийг ч бид их таниулсан. Гэтэл энэ ЖДҮ-лэлийн хүртээмжийг нэмэгдүүлэе гэдэг энэ саналыг оруулахад бас дэмжигдээгүй л дээ. Тэгээд би энийг бас эргэн санууль гэж бодож байна. Яагаад гэвэл зарим нь бол энэ зүйл дээр бас анзаараагүй өнгөрсөн байх. Тэгээд бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийнхэн өнөөдөр өөрийнхөө тохирсон аж ахуйг эрхлэх гэхээр яг үнэндээ хамгийн чухал асуудал бол хөнгөлөлттэй зээл олдохгүй байгаа шүү дээ. Тэгээд том компаниуд бол энэ зовлонг мэдэхгүй л дээ. Тэгэхээр энэ зүйлийг цаашдаа бас анхаарах хэрэгтэй. Ер нь ингээд төсвийн

алдагдлыг бууруулна гэхээр ганцхан төсвөө танаж хасаад, тэгээд бид их сайхан төсөв залруулчихлаа гэж бол болохгүй гэж бодож байна.

Харин энийг зарим зүйлүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай, ард иргэдэд хэрэгтэй, хувийн хэвшилд хэрэгтэй зүйлийг бид бол эндээ хэлэлцэх нь зүйтэй л гэж үзэж байгаа юм. Түүнээс автоматаар ингээд энэ, энийг нь хаслаа гээд зөвхөн хасах зүйл гэдэг байдлаар бас битгий хандаасай гэж бодож байна. Тэгээд үр ашигтай байх энэ зүйл бол хамгийн чухал.

2 дугаарт нь Их Хурлын гишүүд бол энэ эдийн засгаа өсгөө, ер нь юм хийж бүтээе хамтарсан Засгийн газрын үед гээд дээр ер нь нэлээн дэмжсэн шүү дээ. Яг энэ төсвийг батлахад бол.

3 дугаарт нь энэ бүсчилсэн хөгжил, нийслэлд тулгамдсан асуудлуудаа шийдье. Дэд бүтцийн томоохон хөрөнгө оруулалтууд хийе гэдгийг бол дэмжсэн. Тэгэхээр би зарим сайд нарт бас хэлье гэж бодож байна. Бас олон эрхэлсэн сайд шинээр нэмэгдсэн. Тэгээд энэ зардлаа бууруулах тал дээр манлайлал үзүүлж ажиллаач ээ гэж хүсэж байна. Зарим шаардлагагүй, хэмнэж болох, хойшлуулж болно гэж үзэж байгаа зардлуудаа бууруулаач. Нийгэмд өнөөдөр бүх юм нээлттэй явж байгаа шүү дээ. Хэн хаашаа Фукоук арал руу хэн, яаж явсан гээд л хэвлэлээр гарч байгаа. Энэ дээр бол яг тодорхой точный хариулт бол би лав сонсоогүй. Тэгээд гэх мэтчилнээр энэ зүйлүүдийг чинь ард иргэд 7 буудлын Должин эмээ мэдээд байна шүү дээ. Сонсоод байна, хараад байна, үзээд байна. Тийм учраас энэ ард түмний хяналтад байгаа учраас энэ зүйлийг бол мэдэрч, энэ зүйл дээрээ зөв зүйтэй ийм алхмыг дахин хэлэлцэх явцдаа хэрэгжүүлээч гэдгийг л албан ёсоор бас хүсье гэж бодож байна.

Тэгээд хамгийн сүүлийн 1 асуулт байна. Энэ орон нутгийн төсвийн орлого, зарлага татаас, тэгээд төвлөрүүлэх орлого гээд энэ зүйлийг сая энэ нэг их дүн бол эзлэхгүй юм байна лээ шүү дээ. Яг үнэндээ орон нутгийн төсөвт бол би бас орон нутгийн удирдлагаар төсвийн захирагчаар ажиллаж байсан. Энэ дээр анзаарахад.

Тэгээд энэ зүйл дээр өөрчлөлт орох юм бол ингээд аудитад 20-ны өдөр өргөн барьчихсан байгаа аймаг. Тэгээд төсвөө 25-ны дотор өргөн барина. Маргааш нөгөөдөргүй. Тэгээд энэ зүйл дээр чинь нэлээн хүндрэл үүсэх юм биш үү. Тэгээд орон нутгийн энэ зүйлийг хөдөлгөхгүй байх ийм бас боломж байдаг уу. Бусад хэмнэж болох, бууруулж болох зарим зүйлээсээ энийг бас хэмнэх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Энэ дээр бас хариулт авъя.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Яг тийм асуудал бас үүсэж байгаа. Орон нутгаа яах вэ гээд. Энийг бас Төсвийн байнгын хороо дээр ч ярилцаж байна. Гишүүд, ялангуяа манай аймгийн дарга байсан гишүүд энэ зовлонг маш сайн мэдэж, ойлгож байгаа. Тэгээд хэдүүлээ ярилцъя. Байнгын хороо дээр ярилцъя. Ямар гарц шийдэл байх нь вэ, одоо бол би шууд хэлж мэдэхгүй байна. Одоо ингээд хориг хүлээгээд авчихаар нөгөө төсөв яг эцсийн байдлаар батлагдах хугацаа чинь бас ингээд хойшилчхож байгаа шүү дээ. Өнөөдөр нөгөө орон нутаг чинь улсын төсөв батлагдсан гээд хүлээж авах ёстой ийм хугацаанууд нь тодорхойгүй болчхож байгаа учраас нөгөө өргөн барьж байгаа төсөв маань ч гэсэн орон нутгийн хувьд бас ингээд зөрчилтэй болчхож байгаа юм. Тэгэхээр энэ талаар хэдүүлээ л их сайн ярилцъя Бадамсүрэн гишүүн ээ. Батжаргал гишүүн бас энийг

Төсвийн байнгын хороо дээр маш тодорхой ярьж байгаа. Тэгээд энийг хуулийнхантайгаа зөвлөө. Зөвлөцгөөе.

**Д.Амарбаясгалан:** Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн тодруулж асууя.

**М.Бадамсүрэн:** Ер нь манайд нэг анхаарах зүйл байна. Ингээд бид чинь нэгдмэл улс гээд нэг хуультай. Тэгээд Өмнөговь ч адилхан, Хөвсгөл ч адилхан, Баян-Өлгий, Дорнод ч адилхан. Тэгэхээр нөгөө ихэнх улсууд ийм холбооны улс байдаг учраас арай муж болгон тусдаа ийм хууль бас зохицуулалттай. Тэгэхээр бид нар энэ ялангуяа төсвийн бодлого энэ төсөвтэй холбоотой зүйл дээр рояалтигийн хуваарилалттай холбоотой зүйл дээр бүс болгонд, орон нутаг болгонд арай өөр ийм бодлого баримтлахгүй бол болохгүй байгаад байгаа. Жишээлбэл сая танилцуулж байна лээ. Ингээд энэ боловсролын Галбадрах гишүүн. Өмнөговь, Дорнод аймаг 2-т багшийн дутагдал хамгийн багатай гээд. Яагаад гэхээр харьцангуй уул уурхайн орлогоос тэнд бас орлого төвлөрүүлж орон нутгийн санаачилгатай ажилладаг учраас энийг шийдсэн байгаа юм. Тэгэхгүй бид нар яг үнэндээ айлын хүүхдүүдээр бодвол бүх хүүхдийнхээ асуудлыг өөрсдөө шийдээд л насанд хүрчихсэн ч гэсэн өөрсдөө шийдээд л яваад байгаа юм. Тэгээд энэ дээр орон нутагт нь жоохон боломжуудыг өгөөч ээ. Энэ улсын төсөв дээр тусгадаг энэ орон нутгийн чанартай зүйлүүдийг орон нутагт нь өөрөөр нь шийдүүлэх хариуцлагыг нь үүрүүлэх .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Жадамбаагийн Баясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Баясгалан:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд бид нар буруутай бол бүгдээрээ л буруутай. Бид нар бүгдээрээ л энэ төсвийг хэлэлцсэн. Тэгээд хориг тавьсан. Энийг бол ер нь бол хүлээн зөвшөөрч байна. Тэгээд энэ дотор бол бас яг жишээ нь Төсвийн тогтвортой байдлын хуулийн 5.1.6-д заасан төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх гэсэн заалтуудыг бүрэн хангаагүй байна гэж Ерөнхийлөгчийн зүгээс оруулж ирсэн байгаа. Тэгээд үүнтэй бол хамгийн гол санаа бол нэгдэж байгаа. Бид нар энэ 126 гишүүнтэй парламент байгуулахдаа хүн төвтэй, хүний эрхийг дээдэлсэн парламент гэж гарч ирсэн. Бид нар бол ярьж байгаа юм болгондоо л хүний эрхийн талаар шигтгэж байгаа юм. Тэгвэл төсөв маань өөрөө ялгаагүй бас л хүн төвтэй байх ёстой. Энэ дээрээ хэдүүлээ бас анхаарах хэрэгтэй байх. Хэрвээ засаж болж байвал мэдээж хасах юмнууд зөндөө байгаа. Энийг бол засаг өөрөө бас шийдэх хэрэгтэй. Бид нар мэдэхгүй эндээс ороод хэтэрхий хасаж болохгүй юмнаас нь хассанаас болоод өмнө нь бол алдаа гарч байсан тийм туршлага, сургамжууд бол бий. Их Хурал хэтэрхий нөлөөлснөөс болоод.

Би юуг хасна гэж дотроо боддог вэ гэхээр жишээ нь нөгөө төрийн өмчит компаниуд байна шүү дээ. 100 гаруй төрийн өмчит компани. Ашигтай ажиллаж байгаа нь хэд билээ. Ашиггүй ажиллаж байгаа 100 компанид 50 мянга гаруй ажилчид байгаа. Тэгвэл тэр ашиггүй ажиллаад байгаа төрийн өмчит компаниудаа цөөлөөч ээ. Энэ чинь нөгөө данхгар төр гэдгийг чинь л харуулаад байна. Тэгэхээр багш ажилчдаасаа хас гэж байгаа юм биш. Тэр төрийн өмчит компаниудаасаа хасаад өгөөч ээ. Боломж байвал.

2 дугаарт гэвэл мэдээж эрүүл мэндийн талаас бол 1 ч төгрөг бид нар хасах эрх байхгүй. Хасаж ч болохгүй. Харин чиг хэрвээ үнэхээр энэ боломж гарч ирэх юм бол бид нар өнөөдөр энэ чуулганд бид нар ингээд л үг хэлээд л сууж байхад 1 өдөрт 14



хүн хорт хавдраар амь насаа алдаж байгаа. Жилдээ 4 мянга гаруй хүн нь амь насаа алдаж байна. Энэ асуудлыг бид нарт бас шийдэх бас боломж гарч байна шүү дээ. Энэ чинь Үндсэн хуульдаа заасан 1992 онд. Бид нар 100 жилийнхээ ойг хийх гэж байна тун удахгүй. Тэгэхэд бид нарын хамгийн гол юм хүний эрх, эрх чөлөө байгаа. Амьд явах эрх. Тэгэхэд амьд явах эрх нь хангагдахгүй байгаа энэ хүмүүсийн төлөө Хавдрын эмнэлэг бид нар барих хэрэгтэй. Хавдрын эмнэлэг барихгүй бол тэр хашаанд нь байгаа төрд хураагдчихсан, нөгөө Хөгжлийн банканд хураагдчихсан байгаа тэр барилгаа ашиглаад маргаашаас эхлээд өвчтөнүүдээ аваад, эдгээгээд өгөөч ээ, эмчилгээг нь хийгээд өгөөч ээ. Маш олон хүн тэнд очероо хүлээгээд байж байна.

Тэгээд тэрний хажуугаар Эрүүл мэндийн сайд бол өмнө нь хэлсэн. Мэдээж өвчлөхгүй байх арга хэмжээг нь авъя. Тэрний хажуугаар өвдчихсэн хүмүүсээ эдгээхийн тулд Хавдрын эмнэлгийн асуудлаа энэ төсөвтөө оруулаад өгөөч ээ гэж бас гишүүдээсээ, яамныхнаасаа гуйж байна. Энэ бол төсөв нь бага ч гэсэн цаана нь маш олон хүний эрүүл мэнд, амь нас, гэр бүл, эдийн засаг бүх юмтай холбоотой шүү. Тэгэхээр хүний эрхийг дээдэлж байгаа энэ парламентын зүгээс засгаасаа хүсэж байгаа юм гэвэл энэ эмнэлгийн төсвийг нэг оруулаад өгөөч ээ. Бэлэн эмнэлэг байгаа юм чинь тийш нь шилжүүлээд өгөөч ээ. Тэгээд өвчтөнүүдээ аваад эмчлээд, Монголоороо эрүүл байя л даа. 1 ч гэсэн Монгол хүн битгий үхээсэй гэж энд би хэлж байгаа юм шүү.

**Д.Амарбаясгалан:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**О.Номинчимэг:** Баярлалаа. Бүгдээрэнд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Зарчмын хувьд бусад гишүүдтэй адил Ерөнхийлөгчийн хоригийг бол дэмжиж байна. Хүлээж авах нь зүйтэй гэж бол үзэж байна. Яг 2 7 хоногийн өмнө бид 11 дүгээр сарын 8-ны өдөр төсвөө баталсан. Яг үнэнийг хэлэхэд төсвийг бол бүгд л засаж сайжруулах шаардлагатай байна. Өшөө жоохон ажилламаар байна гэдэг санал хэлж байсан боловч, яг 2 дугаар хэлэлцүүлгийн дараа дэг байхгүй учраас батлаад, тэгээд төсвөө тодотгоё гэдэг ийм шийдэл орсон. Тэр үед бол бас засмаар байгаа төсвөө баталчхаад, тэрний дараа авах гэж байгаа арга хэмжээ маань ч гэсэн тэгвэл хуулийн дагуу байх ёстой шүү гэдэг байр суурийг илэрхийлж байсан. Бид өнөөдөр тэгээд хоригийг бол бараг хүлээж авах байх. Тэгээд энэ хоригийг хүлээж авсны дараа дахиад төсвөө бид нар тэгвэл яаж засаж, сайжруулж ямар дэгээр явах вэ гэдэг дээрээ бас анхаармаар байгаа юм. Дэг байхгүй гэж байсан. Одоо бол 2 хэлэлцүүлгээр явах уу, 4 хэлэлцээр явах уу. Дэгээ зохионо уу гэж байна. Тэгээд энэ дэг дээр бид нар дахиад алдалгүй, зөв яваасай гэж бодож байгаа болохоор үүнтэй холбоотой 2 асуудлыг тодруулах гэсэн юм.

1 дүгээрт, 2 үндэслэл байгаа. Хориг дээр эхний үндэслэл бол ингээд харахаар ер нь бол энэ эгзэгтэй цаг үед болбол мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэсэн ийм ард иргэдийн саналыг тусга, намууд бол өөрсдийнхөө зорилтуудыг биелүүл. Одоогийн төсөв чинь бол Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Төсвийн тогтвортой байдлын 5 дугаар зүйл гээд хэд хэдэн заалт байгаа. Энэ заалтууд бол ерөнхийдөө бүгдээрээ төсвийн зохистой удирдлагын зарчим, эсвэл төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчмууд байгаа юм. Ер нь дандаа ерөнхий нөгөө төсвийг бид нар авч явахдаа, удирдахдаа зарчим байгаа юм. Тэгээд зарчмаа бид нар хэрвээ зөрчсөн гэж энэ агуулгаар бид нар хоригоо хүлээж авах юм бол энэ зарчмыг зөв болгохын тулд төсөв өөрөө дахиад бодлогоо өөрчилбөл Сангийн яамнаас өөрөө энийг бол дахиад хийж орж ирэхээс

өөр аргагүй байх гэж бодож байна. Үүнтэй холбогдуулаад гэхдээ ингээд яах вэ зарчим байгаа боловч энэ дээр яг бид нарын хувьд бас нэг шинээр орж ирж байгаа мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэсэн үг орж байгаа. Тэгэхээр яг энийг яг ямар утгаар бас хоригийн агуулгад оруулсан. Энийг илүү тодруулж өгөөч ээ гээд.

2 дугаар үндэслэл бол дагасан хуультай холбоотой, дагасан тогтоолтой холбоотой байгаа. Энэ бол ойлгомжтой байх. Ингээд дүгнэлт дээрээ Монгол Улсын 25 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь хориг тавьсан гэж байгаа. Анх 9 сард бол Засгийн газраас төсвийг өргөн барихдаа мэдээж төсвийн хүрээний мэдэгдэлтэй хамт, улсын төсөв, нэгдсэн төсөв маань өөрөө 2025 оны төсвөөс гадна Эийгмийн даатгалын 2025 оны төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсөв, Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсөв гээд ингээд орж ирдэг. Тэгэхээр энд хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулсан гэдэг дээр эдгээр ийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Үндэсний баялгийн сангийн төсөвт бас багтаж байгаа юу. Үүнтэй холбогдоод мэдээж сая бас байр суурь илэрхийлэгдэж байна. Алдагдалгүй төсөв батлах шаардлагатай байна гээд. Энэ алдагдалгүй төсөв батлах энэ шаардлагын хүрээнд болохоор бид нар хэдийгээр дагаж орж ирээгүй боловч төсвийн хүрээний мэдэгдэл дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлдээ өөрчлөлт оруулах шаардлагатай болох нь. Хэрвээ ингэж энд багтаж байгаа гэж үзэж байгаа бол бид нар яалт ч үгүй энэ бол дэгийнхээ дагуу Засгийн газар өөрөө бодлогоо боловсруулаад, сууриар нь оруулж ирж бид нар 4 удаагийн хэлэлцүүлэг хийхээс өөр аргагүй болох нь гэж би бол харж байгаа юм. Тэгэхээр энэ 2 зүйлийг тодруулж өгнө үү гээд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Занданшатар дарга болон Сангийн сайд бас энэ дээр нэмэлт тайлбараа хийвэл их сайн байна гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх Даваадалай зөвлөх хариулах уу. Мөчлөг сөрсөн эдийн засгийн бодлого гэдгийг юу гэж ойлгох вэ гэж асууж байна.

**Б.Даваадалай:** Номинчимэг гишүүний асуултад хариулъя. Бид нар бас үндэслэл дээрээ маш тодорхой бичсэн. Мэдээж эдийн засгийн гүйцэтгэл бол бас эхний 10 сараар харьцангуй гайгүй явж байгаа. Сүүлийн 2 жилийн хугацаанд бас нэг талдаа нүүрс нэлээн бид нарын экспорт сайн хийлээ. Түүхий эдийн үнэ бас харьцангуй гайгүй байлаа. Гэхдээ гадаад нөхцөл байдал, бусад зүйлээс хамаарч бас тодорхойгүй байгаа учраас илүү болгоомжтой хөрөнгө мөнгө арай жоохон нэмэгдэж байгаа энэ үед илүү хамгаалалттай болгоомжтой байх тал дээр энэ мөчлөг сөрсөн бодлогоо хэрэгжүүлье гэж байгаа юм. Үндсэндээ хөрөнгө мөнгөтэй байх үедээ илүү болгоомжтой хадгалж, хүнд хэцүү цагт илүү дэмжлэг үзүүлэх энэ бодлогын хэлбэр лүүгээ оръё гэж. Ер нь өнгөрсөн 20, 30 жилийн хугацаанд эдийн засгийн бодлогыг гадна дотнын байгууллагууд үнэлэхдээ илүү мөчлөг дагасан шинжээр явсан гэж л хардаг. Тийм учраас энэ удаад Ерөнхийлөгчийн хоригийн 1 том зарчмын үндэслэл бол одоо бүгдээрээ илүү мөчлөг сөрсөн, илүү болгоомжтой, илүү эдийн засгийн тогтвортой байдал руугаа чиглэсэн байдал руу томоохон алхам хийе гэж бас эхний үндэслэлийг оруулж ирсэн. Тийм учраас энэ мөчлөг сөрсөн бодлогыг бол өндөр өсөлттэй бас боломж байгаа жилүүд дээрээ илүү болгоомжтой хандъя, нөхцөл байдал хүндрэх, гадаад орчин нөхцөл байдал тодорхойгүй байгаа учраас болгоомжтой байя гэдэг байдлаар оруулсан шүү гэдгийг бас танд хэлье.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд хариулт адилхан гэж байна. Занданшатар дарга. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

**Г.Занданшатар:** Энэ их чухал асуулт байна. Тэгэхээр Ерөнхийлөгч Төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль, холбогдуулж боловсруулсан хуулийн төслүүд бүхэлд нь хориг тавьсан. Тэгэхдээ Нийгмийн даатгалын сангийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн хууль, Төсвийн хүрээний мэдэгдлүүд тусдаа үзэл баримтлалтай, тусдаа хуулиуд. Тэгэхээр энэ яаж хэлэлцэх вэ гэдэг үндсэн хориг төсвөөсөө илүү яаж хэлэлцэх вэ гэдэг нь илүү маргаан болоод байгаа учраас ажиглахад хоригийг хэлэлцдэг Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заачихсан байгаа. 90.8-д Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан бол хууль, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгох шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль тогтоолын төслийг хэлэлцэн баталж болно. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах бол тухайн шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй” гээд 90.8, 90.9 хоёрт .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн асуулт асууна. Үг хэлнэ.

**Ч.Лодойсамбуу:** Оройн мэнд хүргэе. Энэ хариуцлагын асуудал л даа ерөөсөө л. Одоо бүр анх удаа энэ танхимд бид нар цугласнаасаа хойш л хариуцлага ярьсан. Өнөөдөр Их Хурлын гишүүд бие биедээ хэлж байна л даа. Энэ бид нарын асуудал гэж. Энийгээ бол ил тод, ил далд бие биедээ зөндөө хэлсэн өнгөрсөн хугацаанд. Яг өнөөдөр энэ хоригтой холбоотой хамгийн том хариуцлага ярих ёстой хүн бол Сангийн сайд өөрөө шүү дээ. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар сайд нар ер нь яг энэ чиг үүрэг нь ямар ажлыг хариуцах, ямар үүрэгтэй вэ гэдгийг тодорхой заачихсан шүү дээ. Эдийн засгийнхаа өнөөгийн нөхцөл байдлыг судалж дүгнэнэ, ирээдүйг нь төсөөлнө, тэгээд төсвөө боловсруулж, бодлогоо боловсруулж орж ирнэ гэж. Өнөөдрийг хүртэл Сангийн сайд хэдэн жил хэдэн засаг дамнаж Сангийн сайд хийж байгаа билээ. Өнөөдрийг хүртэл энэ үнийн өсөлт, энэ ажилгүйдэл, энэ авлига, хээл хахууль энэ төсөв сангийн үүдэнд сууж байгаа тантай шууд холбоотой шүү дээ. Төсөв анх өргөн барихаас эхлээд л Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь хэлж байсан. Аудитор нь хэлж байсан. Эдийн засагчид нь хэлж л байсан шүү дээ. Юу ч сонсдоггүй, хэнийг ч сонсдоггүй. Тэгээд эцсийн дүнд нь ингээд нэг ийм хориг тавиулаад, Засгийн газар нь, Их Хурал нь ч гэсэн эвгүй байдалд орчихсон ингээд суугаад байдаг. Бүгд л анхнаасаа хэлж байсан. Ер нь таныг анх төсвөө оруулаад ирэхэд анхны Байнгын хороо дээр хүртэл бид нар хэлж л байсан. Болохгүй байна. Болж байна л гээд зүтгээд байсан. Одоо хориг тавингуут, харин тийм ээ гээд суучихдаг. Монгол төр тоглоом биш шүү дээ.

Монгол Улсын Ерөнхий сайд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр сайд нартаа бие даагаад хариуцлага тооцдог эрхтэй болчихсон. Энэ Сангийн сайдад хариуцлага тооцох эрхтэй. Олон жил харлаа шүү дээ бид нар энэ Сангийн сайдын оруулж ирж байгаа төсөв, гарч байгаа үр дагавар. Төсвийн тэлэлт, урсгал зардал бол тэр чигтээ хувийн хэвшлийн санхүүжилт гээд байгаа. Хувийн хэвшлийгээ дэмжиж байгаа гээд байгаа. Үгүй шүү дээ. Нийтдээ 220 мянган аж ахуйн нэгжүүд байна. Тэрний 70, 80 мянга нь НӨАТ төлөгч байна. Яг энэ төрийн зарлаж байгаа тендерийг чинь 1 даргыг



дагасан 5, 6 мянган компани л хийж байгаа шүү дээ. Тэд нарын л мөнгө шүү дээ. Энэ дарга нарын л мөнгө шүү дээ. Энэ танхимд сууж байгаа. Ийм хариуцлагагүй байж болохгүй. Ийм хариуцлагагүй Сангийн сайдтай Ерөнхий сайд өөрөө хариуцлага тооцох ёстой. Энийг бас олон нийт шаардах хэрэгтэй.

Бид нар энэ хэрэглэгч орон гэдгийг маш олон эдийн засагч нар хэлж байгаа шүү дээ. Сэтгүүлчдийнхээ үгийг сонсохгүй. Эдийн засагчдынхаа үгийг сонсохгүй. Манайх хэрэглэгч орон. Үйлдвэрлэгч орон биш ээ. Энэ их алдагдалтай төсөв, энэ их төсвийн тэлэлт, энэ их урсгал зардлын хэдэн их наядаар нь нэмээд орж ирж байгаа болгон чинь ханшийн өсөлттэй гээд хүн болгон хэлж байна шүү дээ. Тэгээд байхад үгүй ээ л гээд байсан. Одоо ингээд хориг тавиад ороод ирэнгүүт дэмжиж байна. Тэгэхдээ энэ бол парламент баталсан. Та нар баталсан шүү гээд суугаад байж болохгүй л шүү дээ. Тэгээд Ерөнхий сайд сонсож байгаа бол Ерөнхий сайд ер нь орж ирэх ёстой байдаг юм уу, үгүй юм уу. Энэ Сангийн сайдтайгаа хариуцлага тооцох хэрэгтэй.

**Д.Амарбаясгалан:** Үг хэллээ. Батын Батбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Батбаатар:** 2024 оны Их Хурал тангаргаа өргөснөөс хойш хоёронтоо төсөв хэлэлцлээ. 7 сард төсвийн тодотгол хэлэлцсэн. Тэр төсвийн тодотгол хэлэлцэж байх үед хэлсэн шүү дээ. Улс төрийн шийдвэрээ эргэж зөв хараарай. 118-ын бүлэг гэдэг бол бие биедээ эрх мэдэл өгнө. Эрх мэдэл өгнө гэдэг чинь төсвийг хэтрүүлнэ. Өргүй зардлыг нэр нэмнэ. Дараа нь биелэгдэхгүй, хоосон ТЭЗҮ, цаас үлдэнэ шүү. Бие биедээ бялуугаа бэлэглээд л явсан шүү дээ. 10 сард төсөв хэлэлцсэн. Мөн төсвийн гүйцэтгэл хүртэл хэлэлцсэн. Хаа байсан хавар хэлэлцэх ёстой зүйлийг энэ жил. Энэ суурь чинь өөрөө буруу байгаад байгаа учраас өнөөдөр Улсын Их Хурал, Засгийн газрын асуудал болоод байна шүү дээ. Засгийн газар орж ирчхээд төсөв хэлэлцэж байх үед та нар алдагдалгүй болгож болно. Хасах зүйлээ хас гээд л хэлээд суугаад байсан. Миний ойлгож байгаагаар. Засгийн газар нь дотоодын нийт бүтээгдэхүүний 25 хувийн төсөвтэй байх ёстой. Хэрвээ энэ чинь 35 тэрбум байдаг юм бол дотоодын нийт бүтээгдэхүүнээ 140 тэрбум болгож өгөх үү гэж асуусан. 140 тэрбум болгож чадна л гэдэг л юм яриад байсан. Ардын нам, Ардчилсан нам, ХҮН нам 3-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг байнга сануулна шүү гэж хэлсэн. Та нарын өөрсдийн сонгогчдоос очиж санал авч ирсэн мөрийн хөтөлбөрөөсөө зөрсөн төсвийг өөрсдөө оруулж ирж, өөрсдөө кнопоо дарж баталсан шүү дээ. 126 гэж хэлээд байх шаардлага байхгүй. 118-ын бүдүүн бүлэг л энэ бүхнийг хийж байгаа шүү дээ. Эрх барьж байгаа 3 нам 1 өнгөтэй болчихсон. Энэ 3 намын хийж байгаа, баталж байгаа төсөв шүү дээ. Улсын Их Хурлын даргыг энэ Улсын Их Хурлыг битгий энэ 118-ын бүлгийг бүрдүүлсэн засаг шиг битгий болчхоорой гэж их олон удаа санал хүсэлт тавьсан. Заримыг нь хүлээж авсан. Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлд Үндэсний эвслийн дарга, манай намын дарга, ХҮН намаас ингээд хүмүүс ороод, тэнд бас нэг мэдээлэл авдаг, санал хэлдэг, таслах эрхтэй болсон. Зарим зүйл дээр нь дэмжсэн. Тэгсэн хэр нь дахиад л 3 намын даргынхаа үгэнд ороод л тэр Төсвийн зарлагын хороо, Хүний эрхийн хороо, Тусгай хяналтын хороо. Эд нар дээрээсээ энэ цөөнх байгаа 8 хүнтэй энэ 2 нам, эвслийг хасаад л байгаа шүү дээ. Эд нар дээрээсээ энэ 8 хүн буюу цөөнхийгөө хасчхаад, тэгээд засагт эрх барьж байгаа нам нь сөрөг хүчин буюу цөөнхийн үүрэг гүйцэтгэж байгаа юм. Цөөнхийн үүргийг засагт нь байж байж хянадаг юм гэж та нарын гайхуулаад байсан зүйл чинь одоо үр дүн нь, үр дагавар нь энэ шүү дээ. Өнөөдрийн төсөв шүү дээ.

Улсын Их Хурал төсөв баталж байх үед би хэлж байсан. Наад дагуулж тогтоол гардаг чинь буруу. Хэрэгжиж эхлээгүй, батлагдаагүй байгаа төсөв дээр хууль нь хэрэгжиж эхлээгүй байхад тогтоол гарна гэж юу байдаг юм бэ л гэсэн. Бид мэдэж байгаа л гэсэн. Энэ суурь утгаа 1 дүгээрт нь бодох ёстой.

2-т нь өнөөдөр Монголд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарахаар ард нь улс төрийн үр дагавар гардаг. Хууль өөрчлөгддөг, засаг солигддог. Ерөнхийлөгчийн хориг орж ирэхээр ард нь үр дагавар гардаг, үр дүн гардаг. Өөрчлөлтүүд явдаг. Дандаа л улс төрийн зорилготой наана нь эдийн засаг, наана нь аж амьдрал, хүний эрх, эрх чөлөө ярьсан зүйлээр. Ерөнхийлөгчийн хоригийг бол Иргэний зориг ногоон нам хүлээж авах ёстой гэж үзэж байгаа. 118-ын бүлэг юу манаргаж, яаж хийж энэ зүйлээ эргэж батлах юм. Тэрийг нь хара ёстой. Өөрчлөх ёстой зүйлээ өөрчлөх хэрэгтэй.

3 дугаар хэлэлцүүлэг болчихсон байхад хий хоосон шоудаад л 2 талдаа дифект оронгуутаа тийм тогтоол дагуулж гаргаж .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүнд нэмж 1 минут өгье.

**Б.Батбаатар:** Тийм болохоор энэ төсөв хэлэлцэж байх явцдаа эрх баригч 3 нам 118-ын бүлэг Төсвийн зарлагын хяналтын хорооноосоо гараа. Өөрсдөө хянаж байгаа төсөв өнөөдөр ингэж батлагдахаас өөр яах юм. Хянадаг, анхаардаг, хэлдэг, сануулдаг зүйлийг нь анхаарах хэрэгтэй. Энэ олонхын бүлэгт би бас талархаж байгаа юм. Олонхоо хүндэтгэж цөөнхөө сонсох хэрэгтэй. Олонх болсон юм бол үүрэх үүрэг ачаагаа үүрээд, хариуцлагаа үүрэх хэрэгтэй. Тэгэхдээ цөөнхийнхөө үгийг сонсдог орчин нөхцөлөө Их Хурал дотор бүрдүүл. Их Хурлын дэгийн тухай хуулиар бидэнд завсарлага авдаг эрх байсан бол энэ төсвийг өнөөдөр ийм байдалд оруулахгүй л байх байсан. Та нарын эрх мэдэлтэй бярдсан, аагисан халууралт чинь өөрсдөө өөрсдийгөө л ийм байдалд оруулж байгаа шүү дээ. Тэрийгээ тэгээд 126-гийн хариуцлага гээд ярь .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Батбаатар гишүүний асуултад зүгээр нэмж мэдээлэл өгөх гэсэн юм шүү. Гишүүдийн асуултад давхцаад байгаа учраас. Тэр тогтоолтой холбоотой хэрэгжиж эхэлсэн, эхлээгүй төсөв гээд яриад байгаа юм. Тэр дээр нэг ийм ойлголт байгаа юм шүү. Төсөв ер нь батлагдсан өдрөөсөө эхэлж хэрэгжиж эхэлдэг. Тоон гүйцэтгэл бол 1 сарын 1-ээсээ эхэлнэ. Ерөнхийлөгчийн хоригийн хугацаа дуусаад, төсөв батлагдаад, хэрэгжиж эхэлж байгаа 1 жишээ юу байдаг вэ гэхээр тендер зарлаж болдог. Ирэх оны төсөв дээр суусан хөрөнгө оруулалтуудыг 11 сарын 15, 12 сарын 1 гэхэд тендер зарлаад хэрэгжиж эхэлж байгаа маш олон тохиолдлууд байгаа. Тэгээд нэг тийм ойлголт байна лээ шүү. Тэгэхээр энийг хуульчид илүү их тэр хууль зүйн талаас нь тайлбарлана биз. Ер нь бол энэ санал хугацааны хувьд санал гаргаж байсан хүн нь би шүү. Тэгээд ингэж болох уу гээд. Тийм учраас энэ дээр бол нэг ийм хууль зүйн өнцгөөс нь бид харж, аль болох энэ тодорхойгүй асуудлуудыг бушуухан нэг тийш нь болгоод ингээд 1 сарын 1, хууль батлагдмагц бүх зүйлүүд ингээд тодорхой болоод явах нь зүйтэй гэдэг ийм байр суурь илэрхийлж байсан юм шүү.

**Д.Амарбаясгалан:** Нямтайширын Номтойбаяр гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Н.Номтобаяр:** Ямар ч байсан Ерөнхийлөгчийн хоригийн үндэслэлийг маш үндэслэлтэй гаргалгаатай бичсэн Тамгын газрын дарга Занданшатар дарга, тэргүүтэй зөвлөхүүд бас талархаж байгаагаа илэрхийлье. Тэгээд өнгөрсөн хугацаанд юу болсон нь та бүгд сайн мэдэж байгаа. Хэдийгээр сөрөг хүчний үүрэг гүйцэтгэж байгаа ч гэсэн энэ төсвийг дагалдуулаад ирэх онд нийгэм, эдийн засаг, санхүү мөнгөний бодлогод үүсэж болох маш том эрсдэлүүд байсан. Инфляц 2 оронтой тоонд хүрэх нь маш тодорхой л байсан. Тэгээд энийг эсэргүүцэж байр сууриа илэрхийлсэн цөөн гишүүдийн 1. Тэгээд харамсалтай нь үнэхээр л хүч түрээлээ Засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлд 0,7 хувь гээд, 1 хувь ч хүрэхгүй өөрчлөлт ороод, 32 тэрбум төгрөг л өөрчлөлт орсон байх. Үндсэндээ ингээд явсан. Засгийн газар сайн ч төсөв барьж болно, муу ч төсөв барьж болно. Гагцхүү Их Хурал энийг хэлэлцэж, эрсдэлгүй, эдийн засгаа тэлэх, үр өгөөжтэй байлгах нь бидний л ажил. Тэгээд шат шатандаа ингээд асуудлууд нэлээн гарлаа. Тэгээд энэ хориг яах аргагүй бас улс орноо бодсон ийм шийдвэр. Энийг ч хүлээж авах болно гэдгээ удаа дараа хэлсэн.

Гэхдээ энэ өнгөрсөн хугацаанд дүгнэлт хийгээд цаашдаа дахиад ийм байдал үүсэхгүй байх тал дээр нь бид нар бас анхаармаар байгаад байгаа юм. Үнэхээр энэ Монгол банкны мөнгөний бодлого энэ төсөвтэй бас нийцсэн үү. Энэ аудитын газар, энэ бүх байгууллагуудын улс төрөөс хараат байх энэ дархлааг бид нар эргэж харах ёстой. Мэргэжлийн байгууллагуудын байр суурь, Их Хурлын гишүүд саналаа өгөх, маш сайн хэлэлцэх энэ боломж бас бүрдсэн үү. Тэгэхээр энэ өнгөрсөн хугацаанд юу болж өнгөрөв. Энэ дээр нэг дүгнэлт хийгээд, дахиад ийм асуудал үүсэхгүй байх тал дээр бид нар нэлээн анхаарах л хэрэгтэй байгаа юм.

Тэгээд ялангуяа гол асуудал нь юун дээр харагдаад байна вэ гэхээр ингээд 2026 оны төсөв жилийн дараа орж ирнэ. Дахиад л ийм асуудал үүснэ. Төсвийн урсгал зардал маш өндөр. Хөрөнгө оруулах эдийн засгаа тэлэх боломж ердөөсөө байхгүй. Эргээд л нөгөө татвар төлдөг, шимтгэл төлдөг нөгөө аж ахуйн нэгж, компани иргэдийн нурууны ачаа дээр дахиад л үүрнэ. Магадгүй татвар шимтгэл өсөхийг ч бас үгүйсгэхгүй шүү дээ. Тэгэхээр хэд хэдэн реформын асуудлуудыг бид нар энэ ирэх жилийн хугацаанд зайлшгүй л хөндөх ёстой болж байгаа юм. Энэ эдийн засаг бизнес дэх төрийн оролцоо, төрийн өмчит үйлдвэрийн газрууд бүгд алдагдалтай. Ёстой азтай нь зэс, нүүрсний үнэ өндөр болохоор л яваад байгаа юм. Тэгээд л энэ төрийн алба. Шууд болон шууд бусаараа энэ чинь 300 мянган хүн байгаа байхгүй юу. Нийт жилийн урсгал зардлыг чинь дийлэнх хувийг л аваад явчхаад байгаа юм. Тэгэхээр яах аргагүй эдийн засгийн суурь системтэй бид нар нэг реформын ажил хөндөхөөс өөр аргагүй болчихсон. Тэгэхгүй бол дахиад л энэ давтагдана. Дахиад л нэг орлого, зарлагын зөрүү гээд л урсгал зардалтайгаа тэмцсэн нэг ийм л асуудал үүснэ. Тэгээд би энийг хэлээд байгаа шүү дээ. Ард иргэд бол энэ парламент, энэ төрд итгэж байгаа зүйл юу ч байхгүй. Хүлээлт ч ердөөсөө байхгүй. Тэгээд л учиргүй мундаг төсөв оруулж ирлээ, бид алсын хараатай хөгжлийг хурдасах зоригтнууд гээд л сүр сүр юм яриад л байсан. Цээжээрээ энэ төсвөө хамгаалаад л Их Хурлаар гараад л явсан.

Бас нэг зүйл бас хөндөөд байгаа юм. Их Хурлын гишүүдийн мэдээж бүрэн эрх гэж байна. Гэтэл энэ чинь бараг энэ чинь 27, 28 сайд байгаа байхгүй юу. Давхар дээлтэй. Тэгээд л 2, 3 карманы гишүүдтэй, кноптой. Тэгээд л хүч түрээд явчихна. Тэгэхээр энэ чинь нэг талдаа ашиг сонирхлын зөрчилтэй. Сайд нар адаглаад Их Хурал дээр бүтэн суугаад, Ерөнхий сайдтайгаа хамт. Тэгээд энэ санал хураалтад бас оролцохгүй байх боломжуудыг бас бид нар хармаар л байгаад байгаа юм. Энэ

Их Хурлын дархлаа, бүрэн эрхийн асуудлууд бас байна. Тэгэхээр энэ бүгд дээр залгуулаад .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Номтойбаяр гишүүнд 1 минут нэмж өгье.

**Н.Номтойбаяр:** Тэгээд цаашдаа энэ төсөв хэлэлцэх дэгээ хэдүүлээ харъя. Мэргэжлийн байгууллагуудын байр суурийг сонсьё. Тэгээд саяхан л энэ Худалдаа Аж Үйлдвэрийн танхимын төлөөллүүд үнэн зовлонгоо өчөөд л хэвлэлээр байр сууриа илэрхийлээд л байлаа. Эдний байр суурийг бид нар сонсоогүй байхгүй юу. Тэгэхээр эдний байр суурийг сонсох, тэгээд энэ эдийн засаг маань яг яаж тэлэх юм. Энэ бизнес эрхлэгчдийн нурууг бид нар энэ төсвийг шинээр хэлэлцэхдээ яаж бас боломжийг нээж өгөх юм. Нэг ийм чиг баримжаатай. Тэрнээс энд тэнд нэг тэвчиж болох зардал гээд мэдээж хасалгүй л яах вэ. Хэдэн тэрбум шүү дээ гээд байх шиг байгаа юм. Үгүй шүү дээ, 1 төгрөг байсан ч бид нар тэвчиж болох үргүй зардлыг хасах л ийм л зарчимтай шүү дээ. Тэгээд ийм л санал хэлэх гэсэн юм.

Тэгээд одоо гол нь энэ төсвөө яаж одоо хэлэлцэх вэ. 2 дугаар хэлэлцүүлдгээсээ эхэлнэ.

**Д.Амарбаясгалан:** Ер нь яах вэ, бас энэ 126 гишүүнтэй болсон парламентад 1 том онцлог гарч ирж байна. Мэдээж Үндсэн хуулиа бүрэн хэрэгжүүлэх, гаргаж байгаа шийдвэр илүү тунгалаг байх, нэлээн чамбай болох тэр боломж нөхцөлүүд бол их олон талаасаа бүрдэж байгаа юм. Зүгээр бидний нэг дутагдалтай байгаа зүйл нь зарим нэг дэгийн зохицуулалттай холбоотой асуудлаас цаг хугацааны болон бодлогын зарим зүйлүүд дээр хоцрох, алдаа дутагдал гаргах нөхцөлүүд бол байгаад байгаа юм. Түүнээс гишүүд маань бас л энэ төсөв өргөн барьснаас хойш төсвөө чанаржуулъя, алдагдлаа багасгая, үр ашгаа нэмэгдүүлъя гэдэг энэ саналууд бол ажил хэрэгчээр маш их гарч байсан. Одоо харин Номтойбаяр гишүүн тэргүүтэй нөхдүүд маань бас энийг зарим нэг нөхдүүд шиг зүгээр ул шагайх хэлбэрээр биш, ер нь Их Хурал энэ дэгээ яаж цэгцэлж, төсвөө яаж баталж, төсвийнхөө үр ашгийг яаж нэмэгдүүлэх юм бэ гэдэг дээр та бүхэн маань өөрсдөө нэлээн санаачилгатай ажиллах нь зүйтэй байна. Тэгэхээр өнөөдөр хэрвээ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авъя гээд Их Хурал маань эцэслэн шийдчихвэл ирэх 7 хоногт хэлэлцэх асуудлынхаа тов дараалалд Ёс зүй, дэгийн байнгын хороо энэ дэгтэй холбоотой асуудлаар хэрхэн хэлэлцэх талаар гишүүдийн өргөн оролцоотойгоор асуудлаа шийдвэрлэх нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа юм. Түүнээс энд Их Хурлын дарга ингэж хэлэлцэнэ гээд шийдчихвэл дэргэдээс ул шагайгаад байгаа хүмүүс хол очиж бас нэлээн юм болох байлгүй. Тэгэхээр энийг бол би дангаараа шийдэх боломжгүй. Даргын дэргэдэх зөвлөл шийдэх боломжгүй Ёс зүй, дэгийн байнгын хороо энэ асуудлыг шийдэх нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа. Яг энэ дээр бид их зөв ойлголттой байхгүй бол саяын яг Номтойбаяр гишүүн нь уансыг нь гаргаад хэлчэж байгаа юм. Улсын Их Хурлын баталсан хуульд хориг тавигдчихсан. Засгийн газар нь өргөн барьчихсан. Одоо Улсын Их Хурал энэ Засгийн газрын өргөн барьчихсан байгаа төсөв дээр сайжруулалт хийх буюу салбарын бодлогын дотоод асуудлууд руу нэг бүрчлэн орох нөхцөл рүү орж байна л гэсэн үг болчхож байгаа юм. Тэгэхээр энэ ажлын хэсэг, Байнгын хороо маш хариуцлагатай ажиллахгүй бол энэ төсөв Занданшатар даргын түрүүн танилцуулж байгаа бас энэ тавигдсан хориг агуулга бүрэн хангагдахгүй бол дараа нь яах вэ гэдэг асуудал хүртэл энд яригдахаар болж байгаа байхгүй юу. Тэгэхээр гишүүд маань энэ дээр маш их хариуцлагатай хандах хэрэгтэй шүү гэж ингэж хэлэхийг хүсэж байна.

Загджавын Мэндсайхан гишүүн асуулт асууж, үг хэлье.

**3.Мэндсайхан:** Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг дэмжиж байгаа. Тэгэхээр сая болоод өнгөрсөн явдал дээр энэ Их Хурлын баталсан төсөв дээр Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан гэж ойлгож байгаа. Тэгээд бид нар нэг зүйлийг л тодорхой болгомоор байна л даа. Төсвийн ерөнхий зорилго чинь бол ерөөсөө л макро эдийн засгийн болон эдийн засгийн тогтвортой орчныг бий болгох, хувийн хэвшлээ дэмжих, инфляцыг хязгаарлах л ийм л үндсэн үүрэгтэй. Тэгээд саяын өнгөрсөн төсөв чинь маш том тэлэлттэй байна гэдгийг бүх гишүүд хэлээд л байсан. Би Төсвийн байнгын хороонд байгаа. Төсвийн байнгын хороо дээр энэ зардлын тэлэлтийг таная гэдэг асуудал явагдсан. Тэгэнгүүт одоо 126 нөхөр хулгай хийх гэж байна. Төсвийн байнгын хороо дээр Засгийн газрын өргөн барьсан төсвийг танаад, тэгээд тойрогтоо аваачиж хөрөнгө оруулалт хийж өөрөө авах гэж байгаа юм шиг ийм байдлаар гишүүд рүүгээ, Төсвийн байнгын хорооныхоо гишүүд рүү дайраад л, тэгээд л тэр Засгийн газрын өргөн барьснаар нь л баталсан шүү дээ.

Батлангуутаа зарим нь босож аваад л Их Хурал бараг хулгайч нар нийлж байгаад маш том ийм алдаа хийчихлээ. Үндсэн хууль зөрчихлөө гээд л эхэлсэн. Тэгээд энэ дээр Их Хурлын дарга бас энэ хуулийн журам байдаг юм уу, хуулийн хийдлийг нь гаргах ёстой байх гэж бодож байна.

Одоо Төсвийн байнгын хороо магадгүй дүгнэлтээ гаргана гэвэл энэ чинь дахиад асуудалд орно. Нөгөө хулгайгаа дахиад хийх гэж байгаа юм шиг юм яриад тийм ээ. Тэгээд Их Хурлын дарга Төсвийн байнгын хороондоо чиглэлээ өгчихөөр нийлээд бид нар тойрог руугаа юм ачаад явах гэж байгаа юм шиг байгаа юм. Тэгээд энэ асуудлаа цэгцлэхгүйгээр тодотголын асуудлыг цааш нь явуулна гэж байхгүй байх гэж бодож байна.

Сангийн сайдаас одоо тодотголоо хийхдээ тэгээд бид нар тэнд төсвийн тэнцэтгэлээ сайжруулахын тулд хөрөнгө оруулалтаасаа хасаад явах уу, хөрөнгө оруулалтаа эрэмбэлэх юм уу, урсгал зардлаа хасах юм уу. Яг ямар бодлогоо баримталж явах юм. Одоо бид нар чинь ингээд 2 дугаар хэлэлцүүлэг хийгээд, төсвөө хасдаг. Эргээд яг төсвийн тодотгол хийе гэсэн тогтоолтой ч мөн ялгаагүй болчих гээд байгаа байхгүй юу. Тэгээд бид нар дахиад Үндсэн хууль зөрчсөн гээд л нэг хэсэг нь гарч ирээд л Их Хурлаа өөрөө өөрсдийнхөө ажлыг үгүйсгээд л байдаг нэг ийм хүмүүстэй л болчихоод байна. Тэгээд энэ дээр хариулт авъя гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Мэндсайхан гишүүний асуултад хариулъя. Тэр сүүлийн хэсэг дээр нь. 11 сарын 8-аас хойш бид юу гэж зүгээр суух вэ, ер нь тодотгол хийсэн ч бай, хориг ирсэн ч бай, алинд нь ч бид бэлтгэл хангаад, ингээд тооцооллуудаа хийгээд явж байгаа. Энэ талаар саналаа Их Хуралд хүргүүлэхэд ч бэлэн байгаа. Одоо хамаагүй ингээд тодорхой ярих юм бол энэ чинь Их Хурлын бас эрхэд халдсан хэрэг болно шүү дээ. Их Хурал дээр, Их хурлын шийдвэр, Их хурлын шийдвэрийн дагуу энэ төсөв дээр өөрчлөлт хийх энэ тохиргоонуудаа хийгээд явах байх. Бидний зүгээс бол мэдээж энэ дээр нэлээн бүтээлч байдлаар олон нийтийн дунд ч тэр Их Хурал дээр ч тэр бий болсон энэ хүлээлтийг хангахаар бид мэдээж ажиллана. Зүгээр яах вэ, саналын хэмжээнд хэлэхэд бол мэдээж урсгал зардал, энэ төрийн байгууллагуудын энэ бүтэц данхайсан томорсон, үр ашиггүй байгаа, үр дүнгүй



байгаа эдгээр зүйлүүд дээр Засгийн газар илүү их үр дүнтэй байлгах тал дээр их сайн ажиллаж, тооцоо судалгаа хийж, эндээс ямар урсгал зардлуудыг танаж болох нь вэ, ямар зарим үйл ажиллагаануудыг зогсоож хязгаарлаж болох нь вэ. Мөн хөрөнгө оруулалтуудыгаа эргэж харж яаж эрэмбэлэх вэ. 1, 2 жил хойшлуулж болох зүйлүүд нь юу байна гээд гэх мэт яг ийм дарааллуудаар бид саналаа бэлдээд хүргүүлэхэд бэлэн байгаа.

**Д.Амарбаясгалан:** Мэндсайхан гишүүн бас зөв зүйлд хөндөж байгаа. Ер нь яах вэ гишүүд маань Байнгын хороон дээр, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан дээр асуудлуудыг шийдвэрлэдэг. Тэгээд шийдвэрлэсний дараа буруу зөрүү юм хийчихсэн юм шиг ингээд зарим нэгэн рүүгээ бас янз янзын асуудал хөндөж байгаа нь гишүүд өөртөө итгэлтэйгээр шийдвэр гаргах нөхцөл боломжид бол бас нэлээн сөрөг нөлөө үзүүлээд байгаа тийм талууд бас ажиглагдаж байгаа.

Тэгэхээр энэ төсөв, хоригтой холбоотой асуудал шийдэгдээд төсөв ахиад хэлэлцэх нөхцөл үүсвэл бас Улсын Их Хурлын гишүүн өмнөх парламентад Төсвийн байнгын хорооны даргаар ажиллаж байсан Ганзоригийн Тэмүүлэн гишүүнээр ахлуулсан ажлын хэсгийг гаргая гэж байгаа юм. Өөрөө Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг ахалж, санаачилж батлуулах ажлыг зохион байгуулж байсан. Өмнөх жилүүдэд бас төсөвтэй холбоотой асуудлаар ажлын хэсгүүдээ голцуу ахалж ажилласан туршлагууд бас байж байна. Мөн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлтэй идэвхтэй хамтран ажиллах боломжийг бас хангалттай бүрдүүлж чадна. Тэгэхээр гишүүд бас энд намын бүлгийн дарга нараараа дамжуулаад, нам эвслүүд намын бүлэггүй намууд нь намын дарга нараараа дамжуулаад ажлын хэсэгт орж ажиллах гишүүдийн нэрийг бас бидэнд ирүүлэх нь зүйтэй.

Ингээд өнөөдөр асуудал шийдэгдчихвэл цаг алдахгүй бид нар ажлын хэсгийг байгуулаад, ажилд нь оруулах нь зүйтэй гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгийг бас хэлье. Тэгээд мэдээж гишүүдийн нийтлэг нэр хүндэд халдсан, төсвийн хулгай хийгдэж байгаа хэлбэрээр ойлголт төрсөн энэ тэр зүйлүүдийг бол бүгдийг нь сайхан засаж залруулах хэрэгтэй гэдгийг бас та бүхэндээ хэлье.

**Д.Амарбаясгалан:** Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Д.Ганбат:** Ерөнхийдөө бол Хууль зүйн байнгын хороо дээр ярьсан зүйлээ бол давтаад байх шаардлага надад байхгүй. Тэгээд Ерөнхийлөгчөөс тавьж байгаа хоригийг бид нар хүлээж авахгүй гээд яах юм. Авч л таараа шүү дээ. Бараг 100 хувь авна даа. Харж байгаарай. Хэдхэн хоногийн өмнө үгүй ээ, энэ шиг сайхан төсөв алга. Бид нар бараг цэнгэлийн манлайд хүрэх гэж байна энэ тэр гээд л яриад байсан. Одоо бол шал өөр эсрэгээрээ ярих юм шиг байна. Тэгээд ямар хүмүүс сонгосон, ямар Засгийн газар ажиллаж байгааг бол ард түмэн хараад сууж байгаа байлгүй дээ гэж ойлгож байна.

Маш их цаг хугацаа алдаж байна. Одоо энэ хангай дэлхий ч хүндрээд эхэлчихлээ. Гэхдээ ийм байлаа гээд бид нар төсвийг хөнгөн хуумгай хэлэлцэж болохгүй. Энэ Сангийн сайдын байнга давтаад байгаа маш зөв. Хүний зөв бурууг би тэгж хэлдэг хүн биш. 1 төгрөг, төсвийн 1 төгрөг болгон үр дүнтэй зарцуулах ёстой гэж яриад байна. Бүр 1 мөнгийг ч гэсэн үр дүнтэй зарцуулах ёстой. Энэ хоригт тэгээд заачихсан байна. Энэ зөв өө. Яг үүнийх нь дагуу бид нар зарцуулах ёстой. Алдагдалгүй байя гэж байна. Үүнээс цааш бол ингээд алдагдалгүй байх юм байна. Тэрийг бид нар бас хуулиа шинэчлээд хийхдээ оруулаад өгчихье. Алдагдал гэдэг

чинь угаасаа л өр шүү дээ. Санхүүжээд явна. Гаднаас л авна. Энийгээ больё гэж байна. Энэ зүйтэй.

Өмнө одоо 2024 оны төсвийн тодотгол бид нар хэдхэн сарын өмнө ярьж байсан. Бас л алдагдалтай ийм төсвийн тодотголоо хэлэлцээд баталж байсан. Тэрийг бүгд санаж байгаа байх. Энэ төсвийн тодотголын дараа бол энэ сайд нар нь фукоук-т хүмүүсээ явуулдаг. Амралт зугаалгын газар. Хайнанд хүн нас бардаг. Өөр одоо 19 сая төгрөгөөр сэтгүүлийн ширээ худалдаж авдаг, тавилгуудаа сольдог. Энэ зүйлийг харчхаад болохгүй юм байна гээд Ерөнхийлөгч бас ойлгож, энэ төсөв дээр бол тавьж байгаа юм байна гэж ойлголоо. Тэр зарчим бол адилхан шүү дээ.

Нөгөө талаараа ингээд зөв юм яриад эхлэхээр, зөв зүйтэй ард түмнийхээ төлөө дуугараад эхлэхээр, ажиллаад эхлэхээр тэр хүмүүсийг буруутгадаг. Тэрний нэг хандлага нь энэ Ерөнхийлөгч рүү бас ээлжил дайралт эхлээд байна уу, үгүй юүц. Ийм байж болохгүй шүү нөхөд өө. Энийг бас Ерөнхийлөгчийн нэр хүнд энэ тэр гээд хуульд заасан тийм зүйл заалт байгаа. Тэрнийхээ дагуу ажиллах ёстой.

Нөгөө талаараа энэ хориг дотор бас маш чухал асуудал байна. Юу байна вэ гэхээр сонгуулиар мөрийн хөтөлбөртөө намууд заасан тэр юм чинь хаана байна гэсэн юм шиг байна. Одоо яг тодорхой юуг энд заагаад байна вэ. Тэрийгээ нэг тодруулаадхаач. Ард түмэн нь засаглах эрхээ мэдээж хэрэг гишүүдээрээ дамжуулж хангаж байгаа байх. Улсын Их Хурлаар. Энэ Улсын Их Хурал нь тэгээд уг нь олонхтой л Улсын Их Хурал шүү дээ. Бид нар тэр олонхоо ажиллуулж үзээд болохгүй бол дараа нь хамтарсан Засгаа байгуулаад явж болох л байсан. Энийгээ жоохон буруу хийгээд явчхав уу. Үндсэн хуулиа ч биелүүлдэггүй ийм болчхоод байна.

Нөгөө талаараа Улсын Их Хурлын гишүүнийг юу хийх, яахыг заадаг хүмүүс байхгүй. Тэрийг ганцхан ард түмэн заана. Ард түмэн тэр үнэлгээ дүгнэлтийг нь өгнө. Засгийн газар ажлаа яаж хийхийг бол бид нар заана. Ингэж хий гэж. Би чадваргүй байна шүү гэдгийг удаа дараа анхааруулж байсан. Төсвийг эхнээс нь буцаа, Засгийн газар тат гэж хэлж байсан. Тэгээд яг ийм байдалд орж байгаа байхгүй юу. Гэх мэтчилний. Энэ төсвийг бид нар дутуу дулимаг хэлэлцэж болохгүй. Бүр эхнээс нь хэлэлцэх ёстой. Бүр өргөн .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгөх үү. Занданшатар дарга. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Занданшатар дарга хариулт өгнө.

**Г.Занданшатар:** Дашдондогийн Ганбат гишүүн 2 асуулт асуулаа.

1 дүгээрт сонгуулийн амлалт гэж яг юу хэлж байна гэж. Тэгэхээр сонгуулийн амлалт нийт улс төрийн намууд төсвийн зарлагыг танаж, данхайсан төрөөс жижиг төр лүү шилжинэ. Инфляцыг хязгаарлана гэсэн ийм нийтлэг олон амлалтууд бий. Тэрнийг иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд сануулсныг зөв зүйтэй хэрэг гэж Ерөнхийлөгч тэмдэглэсэн. Тухайлах юм бол энэ урсгал зардлын өсөлтийг танахгүй бол инфляцад үзүүлэх нөлөө, ханшид үзүүлэх нөлөө нийт 3,5 сая хүний амьдралд сөргөөр нөлөөлнө. Энэ 2,5 тэрбум долларын үзүүлж болзошгүй импортын төлбөрийн тэнцэлд үзүүлж болзошгүй дарамтыг стресс тестээр шалгаж үзээд, ингээд төлбөрийн тэнцэл төсвийн хос алдагдалтай явж ирсэн өнгөрсөн 25 жилийн хугацаанд өнөөдрийн манай ханш тэнгэрт тултал өсөөд,

ханшаас шалтгаалсан импортоор өдөөгдсөн инфляцын хувь хэмжээ ард иргэдийн амьдралд сөргөөр нөлөөлж байна. Ийм учраас нийт ард түмний эрх ашиг төсөвт бүрнээ нийцнэ гэж үзэж энэ хоригийг тавьсан бөгөөд энэ төсвийн алдагдалгүй батлах шаардлага бол энэ юм. Үр ашиггүй зардлаа хэмнэж байж л төсөв алдагдалгүй батлагдаж байж, энэ өрийг нэмэгдүүлэх, инфляцыг өдөөх хүчин зүйлүүдийг хязгаарлахгүй бол гадаад тогтворгүй байдал дотоод иргэдийн амьдралд нөлөөлж болзошгүй учраас Ерөнхийлөгч энийгээ тавьсан.

Ийм ч учраас Ерөнхийлөгчийн нэр хүндийг Монгол Улсын хуулиар хамгаалдаг. Төрийн тэргүүн Монгол Улсын үндэсний эв нэгдлийг илэрхийлэгч төрийн тэргүүний хувьд гаргаж байгаа шийдвэр, хоригтой нь холбогдуулж нэр төрд нь халдаж байгаа аливаа үйлдэл, үйл ажиллагааг улс төрийн зорилгоор ашиглаж байгаа үйл ажиллагааг бол хуулиар хориглосон байдаг бөгөөд холбогдох байгууллагууд нягталж шалгаж авдаг юм. Энэ бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал гэж үздэг хуулиараа. Ийм учраас нийт ард түмэн, улс орны нийт иргэн, улс орны эрх ашигт нийцүүлж энэ хоригийг тавьсан. Ийм учраас энэ төсвийг алдагдалгүй батлах нь бол одоогийн цаг үеийн шаардлага гэж үзэж байгаа. Ер нь энэ хоригийг бол хялбаршуулсан журмаар хэлэлцээд Дэгийн тухай хуулийн 90.8, 90.9-д зааснаар бусад тэр 53 хуулиар 3,5 их наядын зардлыг нэмэгдүүлээд байгаа, өдөөгдөж байгаа бүх хуульд нэмэлт, өөрчлөлт орох боломжийг хориг өөрөө нээж өгч байгаа юм. Бүхэлд нь хориг тавьж байгаа нь бүх эдийн засгийн тохиргоо, төсвийн тохиргоо хийх боломжийг нээж өгөх зорилгоор бүхэлд нь хориг тавьсан.

Түрүүн бас Хавдрын эмнэлэг олон асуудлууд гарсан. Зүгээр нэгтгээд хэлэхэд бол энийг эдийн засгийн зохицуулалтууд, Хөгжлийн банк, банкны зээлийн эргэн төлөлт олон шугамуудаар бас зохицуулах боломжит санхүүжилтийн болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн олон арга механизмуудыг ашиглаж энэ үргүй зардал нэмэгдүүлж байгаа нэн шаардлагатай биш хөрөнгө оруулалт, зардлуудыг танах бололцоонууд байгаа гэж үзэж байгаа юм. Ийм учраас энд 1,9 их наядын зардлыг хэмнэх тооцоо боломжийг гаргасан. Үр ашиггүй энэ зардал болгон бол инфляц, үнийн өсөлт, ханшийн .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Ганбат гишүүн тодруулж асуух уу. Сая гар өргөх шиг боллоо. Ганбат гишүүний микрофоныг өгье. Тодруулж асууя.

**Д.Ганбат:** Ингээд төсвийг бол эхнээс нь ах авхуулаад ингээд хэлэлцэх нь зүйтэй гэж ойлгож байна. Мэдээж хэрэг энэ төсвийн одоогийн хуулиар бол тийм сүрхий өөрчлөлт оруулах боломж нь бол хязгаарлагдмал байгаа шүү дээ. Нөгөө талаар бол одоо тэр урсгал зардлуудыг нь бид нар батлаад өгчих хэрэгтэй. Бас хүмүүсийн цалин пүнлүү тэр бүх юм нь бол хэвийн явж байгаа. Америкт ч гэсэн тийм л байдаг шүү дээ энэ чинь. Төсвөө хэдэн сараар хэлэлцээд, болохгүй бүтэхгүй бол буцаадаг.

Нөгөө талаар бол одоо бас Засгийн газар, Ерөнхий сайд бас доторх сайд нартайгаа хариуцлага ярих хэрэгтэй. Энэ цаг хугацаа энэ юм хум ард түмнийг бас ийм байдалд оруулж байгаа энэ нөхцөл байдлыг бол дүгнээд энэ юмаа хийх хэрэгтэй гэж ойлгож байна. Тэгэхгүй бол өнөөдөр хаяанд өнөө маргаашгүй л цас зуд болж байна.



Тэгээд баруун аймгийнхан, зүүн аймгийнх нь бол төсөв бол хангалттай аваад байх шиг байгаа юм. Ялангуяа манай Өвөрхангай, Баянхонгор, Архангай .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Б.Түвшин:** Та бүхнийхээ энэ өдрийн амрыг айлтгая. Тэгээд Ерөнхийлөгчийн хоригийг бол хүлээж авах нь зүйтэй. Энд бол үндэслэлүүдийг маш товч бөгөөд маш тодорхой тусгасан байгаад байгаа. Би хэдхэн тоо дурдъя. 2022 онд төсвийн урсгал зардал 14,2 их наяд, 2023 онд 17,1 их наяд, 2024 онд 21,2 их наяд. Энэ үед бол сонгуулийн төсөв гээд асар их том тоо гэж ярьж байсан. 2024 оны тодотгол хийгээд 22,5 их наяд, сая 2025 онд одоо ингээд 26 их наяд болж орж ирж байгаа юм. Энэ асар их өсөлтийн тоо. Ерөөсөө бид нар энэ төсвийн зардлуудыг ингэж хязгаарлаж байхгүй бол одоо энэ Засгийн газрынхны яриад байгаа бас үнэн шүү дээ. Сангийн сайд энэ тэрийн яриад байгаа. Байшин нэмэгдэж байна. Араас нь зардал гарч байна. Орон тоо нэмэгдэж байна. Араас нь зардал гарч байна. Тэр байр савны чинь ашиглалт, харуул хамгаалалт, засвар үйлчилгээ гээд бүгд орж ирж байна. Ерөөсөө энэ төсвийг тодорхой байшин савтай, орон тоотой болгох дээрээс нь тодорхой бодлогуудыг цэгцлэх цаг болж. Энэ удаагийн төсөв дээр ч гэсэн тодорхой хэмжээний зардлыг бууруулах боломж байгаа. Үр ашиггүй зардлуудаа бууруулахгүй бол энэ өөрөө эдийн засгийн макро үзүүлэлтэд нөлөөлнө.

Төсвийн тодотголын үеэр ярьж байсан шүү дээ. 126 Их Хурлын шинэ гишүүд бид нар юугаа ч мэдэхгүй байж байгаад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчилчихлөө шүү. Үүний үр дүн бид нарт муугаар гарна гэж хэлж байсан. Одоо яг энэ үр дүндээ бид нар тулж ирээд байна шүү дээ. Төсвийн тогтвортой байдлын 6.1.3 бол тухайн төсвийн зардлын өсөлтийг хязгаарласан. Ялангуяа уул уурхайн бус эдийн засгийн өсөлтийн хэмжээгээр болбол тодорхой зардлуудаа өсгөхийг зөвшөөрдөг энэ заалтыг бид нар аваад хаячихсан. Тийм учраас энэ удаа ч зардал хасах ёстой. Цаашдаа ерөөсөө энэ төсвийн зардлын өсөлтийг хязгаарласан энэ 6.1.3 болон 6.1.2-ыг буцааж сэргээх, үүнтэй дүйцэхүйц хэмжээний шалгууруудыг бид нар бас Төсвийн хүрээний мэдэгдэл тусгай шалгуурууд дээрээ оруулж ирэхгүй бол энэ байдал бол тасархайгүй юм байна гэдгийг хэлье.

3 дугаарт энэ дотоодын нийт бүтээгдэхүүний тухай ярьж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг орлогоор, зардлаар, үйлдвэрлэлийн аргаар гээд 3 аргаар тооцдог. Өнөөдөр нэг хэсэг зам, 1, 1 барилга баригдаад дотоодын нийт бүтээгдэхүүн өсчих тухай яриад байдаг. Гэтэл энэ чинь иргэдэд яаж өсөж байгаа юм. Ямар арга замаар тооцож байгаа юм. Үнэхээр энэ дотоодын нийт бүтээгдэхүүн нь Монголын иргэдийн эдийн засаг, Монгол Улсын эдийн засагт нөлөөлөхүйц юм уу зүгээр тэр удаагийн ажил гүйлгээний нэмэгдэл юм уу гэдгийг бид нар ялгаж, харж тооцож, макро эдийн засгийн үзүүлэлтүүдээ дахиж нэг шинэчилж харах зайлшгүй шаардлагатай байна. Төсвийн шинэчилсэн бодлогыг дахиж явуулах хэрэгтэй. Уралдаж булаацалдаж тавьдаг биш, дээрээс нь тогтвортой хийдэг хамгийн сайн сайд гэдэг бол төсвөө бууруулж, үр ашигтай хүртээмжтэй төрийн үйлчилгээгээ хүргэж чаддаг, оновчтой бодлого явуулдаг хэлнэ үү гэхээс биш, өнөөдөр хамгийн их төсвөө тавьж байгаа, хамгийн их зардал тавьж байгаа, тэрийгээ батлуулж чадсан сайд бол хамгийн том мундаг сайд болдог гэдэг ийм нийтлэг жишиг тогтчихсон байна. Энийг бид нар бүр үндэс сууриар нь өөрчилж, төрийн бүх үйл ажиллагааны процессыг дахин инженерчлэх хэрэгтэй.

Цахим хөгжлийн яам бол энэ орон тоо, байшин савнуудыг бол бууруулах ёстой шүү дээ. Дор хаяж 10-20 хувь бууруулах ёстой. Ялангуяа энэ сайд болгон доошоогоо орон нутагтаа тулсан бүтэцтэй биш. Хэд хэдэн яамдууд нь дээрээ бодлогоо нэг гаргаад, доошоо хүртээдэг газрууд нь 1 цэгүүд байхгүй бол сум болгонд байшинтай, аймаг болгонд бүгдээрээ дархлагдсан том том байшин савуудтай. Тэр нь тэгээд зардал гарч байдаг. Тэр нь тэгээд дандаа улсын төсвөөсөө мөнгө нэхэж байдаг ийм байдал байгаа шүү дээ. Ийм учраас төсвийг энэ удаадаа бол алдагдалгүй болгох зайлшгүй шаардлагатай. Төсвийг тасралтгүй бууруулах бодлогыг явуулах хэрэгтэй. Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хүрээний шаардлагуудаа илүү сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

**Д.Амарбаясгалан:** Үг хэллээ. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа. Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн бас хориг бол орж ирж байна. Тэр дундаа Улсын Их Хурлаас өнгөрсөн 7 хоногт бид бүхний бас баталсан хууль тогтоолууд дээр бүхэлд нь хориг тавьж байна. Зарчмын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг би бас хувь хүнийхээ хувьд талархан хүлээж авч байгаа. Манай Улсын Их Хурал, Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн энэ асуудал дээр бас бүгдээрээ дэмжиж хүлээж авч, хүлээн авна гэдэгт бас би итгэлтэй байгаа. Энэ асуудлыг гаргаж ирж тавьсан гол үндсэн суурь асуудал маань бол үндсэндээ бид бүхэн энэ улс орны эдийн засгийг энэ төсвөөс бол салгаж ойлгох боломж бололцоо байхгүй. Тухайн тэр төсвийн бодлого хэр байна, түүнийх нь тусгал нь бол дараа жилийнхээ улсынхаа эдийн засаг дээр, ард иргэдийн амьжиргаа орлого дээр тусгалаа олдог, нөлөөлдөг ийм зүйл байгаа. Хэрэв төсвийн бодлого буруу явах юм бол үндсэндээ улс орны эдийн засаг дээр тэр хэмжээний буруу нөлөөлөл тусгал бол гарна л гэсэн ийм зүйл байгаа юм.

Тэгэхээр бид бүхний хувьд гол анхаарах асуудал маань бол эдийн засгийн тогтвортой байдал. Ард иргэдийн амьжиргаа, орлогыг нь хэрхэн хамгаалах. Эргээд цаашид магадгүй яг үндсэндээ энэ Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг дээр тавигдсан байгаад байгаа гадаад нөхцөл байдал өөрөө эрсдэлтэй байгаа цаг үе дээр бид бүхэн Монгол Улсын хэмжээнд төсвийн болон мөнгөнийхөө бодлого дээр өөрсдөө бид бүхэн нөөцөө бүрдүүлэх, хуримтлалаа бий болгох л ийм зайлшгүй бодит шаардлага бол байна гэдэг асуудал байгаа. Энэ хэмжээгээрээ бид нар цаашид энэ макро эдийн засгаа хамгаалах, тэр дундаа ард иргэдийн авч байгаа цалин хөлс нь ирэх жил амьдралдаа хүргэдэг байх. Бид бүхний нэмж байгаа тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдлүүд нь илүү бодитойгоор тусах, бодит орлогыг хамгаалах л ийм нөхцөл байдал бол үүснэ гэж бас харж байгаа. Ерөнхийлөгч бол энэ дээр угаасаа тодорхой чиглэлүүдийг бол өгсөн байгаа. Үр ашигтай байлгах, хэмнэлттэй байлгах, алдагдалгүй төсвийг батлах гэдэг асуудлыг тавьж байгаа юм.

Үүгээрээ бол нэг талдаа нэг суурь зарчмын том босгыг бол гаргаж ирж тавьж байна гэж харж байгаа юм. Хамгийн доод босго бол үндсэндээ алдагдалгүй буюу 1,9 их наядаар бол доод тал нь төсвийн зардлыг бууруулах энэ зарчмын асуудлыг бол тавьж байна. Энийг бол талархан дэмжиж хүлээж авч байгаа. Ингэж байж бид нар цаашдаа энэ инфляцыг хязгаарлах, эргээд юу гэдэг юм бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг ч гэсэн хязгаарлах боломж бол бүрдэнэ гэж бас харж байгаа. Одоо Улсын Их Хурал бол үндсэндээ бид бүхэн энэ асуудал дээр хариуцлагатай хандах ёстой. Ажлын хэсэг мэдээж энд бол гарч ажиллах байх. Бид бүхэн дараа дараагийн жилүүд дээр бол бас зөв жишгийг тогтоох, зөв хандлагыг бүрдүүлэх ийм төсвийг бол

Улсын Их Хурал энэ удаагийн 2025 оны төсөв дээр бол батлах ийм түүхэн хариуцлага ноогдож байна. Ноогдож байна.

2 дахь асуудал бол үндсэндээ бид нар 2025 оны төсвийн дараагаас, энэ хоригийн дараагаас энэ 2025 оны төсвийг залруулсны дараагаас яах юм бэ гэдэг асуудал байгаад байгаа юм. Тэгэхээр би бол хувь хүнийхээ үүднээс бодож байгаа зүйл бол дараа дараагийн парламент дээр, дараа дараагийн жилийн төсвүүд дээр бол ийм алдаанууд битгий гаргаасай. Бид бүхний сая энэ жилийн төсвөөс авсан том сургамжийг бид нар залруулах боломж бололцоо болгож ашиглаасай гэж хараад байгаа юм.

Энэ өөрөө юу юм бэ гэж авч үзэхээр бол өнгөрсөн энэ оны 8 сард төсвийн тодотголоор Тогтвортой хуулийн тухай хууль дээрээс авсан 1 заалт байгаа. Энийг бид нар буцааж сэргээх ёстой. Би хувь хүнийхээ үүднээс бол ирэх ондоо багтааж энэ хуулийн төслийг бол өргөн барья гэж бодож байгаа юм. Энэ заалтыг буцааж сэргээх. Энэ өөрөө юу юм бэ гэж авч үзэхээр үндсэндээ Монгол Улс бол угаасаа уул уурхайн салбараас бүрэн хамааралтай улс орон. Нэг салбараас бүрэн хамааралтай. Тэр дундаа 1 бүтээгдэхүүнээс хамааралтай. Тэгээд бид бүхний хувьд энэ уул уурхайн гэнэтийн орлогоос, савлагаанаас эдийн засгаа хамгаалсан байсан 1 заалт бол угаасаа Тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3 дахь заалт байгаад байгаа юм. 1.3 дахь заалт. Өмнөх жилийнх нь зарлагын өсөлтөөс бид нар уул уурхайнх нь бус юу гэдэг юм салбарын өсөлтөөр жигнэж байж, дараагийнх нь жилийн зардлын өсөлтийг дэмнэдэг байя. Уул уурхайн гэнэтийн орлогоос бол хамгаалдаг байя гэсэн заалт байсан. Энэ бол нэг талдаа Монгол Улсын төсвийн бодлогын хамгаалалт байсан. Энэ бол бид бүхний уул уурхайн эрсдэлээс хамгаалах гол заалт байсан. Энийг бол бид нар хийх ёстой гэж бол харж байгаа. Хувь хүнийхээ үүднээс бол энэ хуулийн төслийг .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Сайнбуянгийн Амарсайхан Шадар сайд асуулт асууж, үг хэлнэ.

**С.Амарсайхан:** 1 асуулт бас саналууд байна. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Занданшатар даргаас асууя. Хориг дээр 2025 оны төсөвт хориг тавих, мөн дагалдах хуулиуд дээр гэсэн байгаа. Тэгэхээр дагалдах аль аль хуулиуд дээр бас энэ хоригийн асуудлууд хөндөгдөж байгаа вэ. Яг аль хуулийг хэлж байна вэ гэдэг дээр хариулт авъя. 1 дүгээрт.

2 дугаарт төсвийн тодорхойгүй байдал энэ эерэг өсөлттэй байгаа эдийн засгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хөрөнгө оруулагчдын бас итгэлийг бууруулах, цаашдаа тогтвортой эдийн засгийн өсөлтийг бий болгох ийм боломж нөхцөлийг хязгаарлах эрсдэлүүд байдаг учраас Монгол Улсын Ерөнхийлөгчийн энэ хоригийг хүлээж авч, хүлээж авахдаа энийг одоо илүү зөв зохистой, дээрээс нь ажил хүлээн авч бодитой бөгөөд гарцаагүй танах ёстой зардал юу байж болох вэ гэдгээ харах нь зүйтэй.

Нөгөө талаараа бол энэ төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн зарлагыг хязгаарлах асуудал. Шинэ орлогын эх үүсвэрийг эрэлхийлэх гэдэг бол ямар ч цаг үед байх ёстой асуудал учраас энэ тал дээрээ бас бодитой тооцоо судалгаатай асуудалд хандах нь зөв гэж үзэж байгаа. Гэхдээ энэ хүрээнд бол нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, тэгээд гарцаагүй орлого бүрдүүлэх ирээдүйн хөгжлийн тогтвортой хөгжлийн стратеги хэрэгжүүлэхтэй холбоотой хөгжлийн

хөтөлбөрүүдийг, төсөл хөтөлбөрийг нь хөрөнгө оруулалтыг нь танах, хасах гэдэг асуудал бас байж болохгүй учраас энэ тал дээрээ манай гишүүд нэлээн анхаарах байх гэж бодож байна.

Хоригийг хүлээн авч шийдвэрлэхдээ бид нар хэд хэдэн зүйл дээр анхаарах хэрэгтэй.

1 дүгээрт нь энэ төсвөө батлах процесс цаашаа яаж явах вэ гээд. Түрүүн дэг дээр заасан. Дэгийн байнгын хороо энэ асуудлыг тодорхойлж, Их Хурлын гишүүдийн олонхоор шийдвэрлэнэ гэсэн саналууд байгаа. Энийгээ тодорхой болгох хэрэгтэй. Улсын хөгжлийн бодлого, санхүүгийн тэнцвэрийг алдагдуулахгүйгээр энэ орлого, зарлагын асуудал дээрээ бас бодитой хандахгүй бол хэт их улс төржөөд энэ Ерөнхийлөгчийн хоригийг улс төржүүлсэн, улс төрийн хэрүүл маргаан болгох эсвэл хувь хүний тийм явцуу улс төр, шоу болгохгүй байх талаас нь хаана хаанаа анхаарч, эдийн засаг, нийгмийн бодит нөхцөл байдал эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлаа хангах талаас нь холбогдох яам, Тамгын газрууд анхаарч ажиллаж, гишүүд ч гэсэн нэлээн тодорхой байр сууриудаа илэрхийлж ажиллах байх гэж бодож байна. Тэгээд яагаад ингэж хэлж байна гэхээр одоо яах вэ, мэдээж бид нар зарлагаа хязгаарлах ёстой. Төсвөө тэнцвэртэй байлгах ёстой. Орлого зарлагаа хянах ёстой. Гэхдээ хянаж байна, хасаж байна гээд хэт үндэслэлгүй, төсвийн алдагдалгүйгээр хийнэ гэх юм бол энэ өөрөө эргээд сөрөг үр дагавар авчирна. Хэдийгээр санхүүгийн сахилга бат, тогтвортой урт хугацааны хөгжлийг хангадаг ийм орлого, зарлагын тэнцвэртэй байдал улс орнууд байдаг ч гэсэн ихэнхдээ хөгжингүй улс орнууд эдийн засаг нь бэхжиж тогтсон улс орнуудад давамгайл хэрэглэгддэг. Энэ агуулгаар бид бол нөгөө талдаа өөрсдөө хөгжиж байгаа улс орон шүү. Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлж байж, дараа дараагийн асуудлуудаа шийдэх, орлого ашиг нэмэгдэнэ шүү.

Тэгэхгүйгээр зарлага гарахгүйгээр ажил амьдрал явахгүй шүү гэдгийг маш сайн тооцохгүй бол энэ бол нэг айлын амьдрал биш, 1 компанийн ажил үүрэг биш, бүхэл бүтэн тусгаар тогтносон улс орон. Тэгээд хөгжлийн замдаа шинэ шатандаа орж яваа гээд анхаарах ёстой, харьцуулах ёстой олон асуудлууд байгаа учраас би .../минут дуусав/

**Д.Амарбаясгалан:** Үг хэллээ. Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дараа нь санал хураалттай гишүүдийг танхимд ирэхийг урьж байна.

**У.Отгонбаяр:** Бүгдэд нь оройн мэнд хүргэе. Ерөнхийлөгчийн хоригийг бол дэмжиж байгаа. Манай Хууль зүйн байнгын хороо бол 100 хувиар Ерөнхийлөгчийн хоригийг дэмжсэн. Байнгын хороо хуралдаж байх үед бас хэд хэдэн зүйл дээр асуултын тэмдэгтэй байсан. Энэ хоригийг ямар горимоор хэлэлцэх вэ. 2 байх юм уу, 4 байх юм уу гэдэг зүйл дээр нэлээн бас асуудал яригдсан. Ямар ч байсан Ёс зүй, дэгийн байнгын хороо дээр энэ асуудлыг бол хэлэлцэж шийдвэрлэх юм байна. Тэгээд Ёс зүй, дэгийн байнгын хорооноос зөвхөн энэ удаагийн Ерөнхийлөгчийн хоригт зориулж дэг гаргах гэж байна уу. Эсвэл цаашдаа яг энийг дагаж мөрдөх чиглэлээр дэгийн зохицуулалт хийх гэж байгаа юу гэдэг ийм асуулт байна. Энийг маш тодорхой нэг талдаа гаргахгүй бол цаашдаа бид бүхэн бас ийм асуудалтай нүүр тулахыг үгүйсгэхгүй. Тийм учраас бас энэ дээр нэлээн тодорхой хариулт байвал Тамгын газраас өгөөч.

Тэгээд өнөөдрийн энэ хоригийг тал талаас нь сайн ярилцаж байгаад бас дэмжээд хүлээж авах байх гэж хувьдаа бодож байна. Тийм учраас цааш цаашдын энэ хууль, эрх зүйтэй холбоотой маргаантай асуудлуудаа бид бүхэн нэг талдаа гаргаж, тодорхой болгож урагшлахгүй бол дахин дахин ийм асуудлуудтай тулбал тулж болзошгүй нөхцөл байдал бас байхыг үгүйсгэхгүй.

**Д.Амарбаясгалан:** Тамгын газраас ажлын хэсгийн 12 дугаар микрофон уу. Хариулт өгье.

**Б.Баасандорж:** Отгонбаяр гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр бас хэд хэдэн гишүүд энэ асуудлыг хөндлөө. Тэгэхээр хэрвээ Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авах юм бол энэ асуудлыг хэрхэн, яаж хэлэлцэх вэ гэдэг асуудлыг бол Ёс зүй, дэгийн байнгын хороо бол Чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэнэ. Ер нь зүгээр Их Хурлын 9 удаагийн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Их Хурлын төсөвтэй холбоотой хоригийг судлаад үзэхээр нийтдээ 9 удаа хориг тавьсан байдаг. Төсөв дээр. 6-д нь бол бүхэлд нь хориг тавьсан. 3-д нь бол хэсэгчилж хориг тавьсан байгаа. Бүхэлд нь тавьсан 6 удаагийн хориг дээр бол Их Хурал хүлээж авч байсан асуудал бол байдаггүй. 1 ч удаа хүлээж авч байгаагүй. 3 удаа хэсэгчилж тавьсан дээр бол 1 удаа хүлээж авсан байдаг. 2005 онд. Тухайн 2005 онд бол Их Хурлын дэгийн тухай хууль байгаагүй. Дэгийг бол тогтоолоор буюу Улсын Их Хурлын тогтоолоор зохицуулдаг байсан.

Тэгэхээр энэ удаад бол яг нарийвчилсан зохицуулсан зохицуулалт хэрвээ Их Хурал хүлээж авах юм бол хэрхэн хэлэлцэх талаар байхгүй учраас энэ дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйл буюу хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх журам буюу Ёс зүй, дэгийн байнгын хороо хэрхэн яаж хэлэлцэх вэ гэдэг 1 удаагийн дэгийг Улсын Их Хурлын тогтоолоор боловсруулаад, чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулаад, хэрвээ гишүүд маань олонхоороо тухайн тогтоолыг батлах юм бол тэр дэгээр энэ хоригийг хүлээж аваад, төсвийг хэрхэн хэлэлцэх вэ гэдэг асуудлаа зохицуулна.

**Д.Амарбаясгалан:** Ингээд гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа. Санал хураалтын үйл ажиллагаа эхлэхээр байгаа. Энэ санал хураалттай холбоотой Баасандорж дарга тайлбар хийх үү.

Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны саналыг дэмжье гэсэн ийм томъёоллоор санал хураах юм. Энэ дээр нэг ойлголт, мэдээлэл өгөөдхөөч. Ажлын хэсгийн 11 дүгээр микрофон.

**Б.Баасандорж:** Улсын Их Хурлын тамгын газар Баасандорж. Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг дээр Ерөнхийлөгчийн бүрэн эрх дээр Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавих, Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний 2/3 нь хүлээж аваагүй бол, хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ гэж байдаг.

Хэрвээ Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авахгүй гэдэг шийдвэр гарах тохиолдолд нийт гишүүний 2/3 байх ёстой. Хуралдаанд оролцсон гишүүдийн. Ердийн олонхоор Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авна гэсэн үг байгаа. Дэгийн тухай хууль, Үндсэн хууль дээр.



**Д.Амарбаясгалан:** Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, хамт өргөн мэдүүлсэн болон холбогдуулан боловсруулж баталсан хууль тогтоомжид бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. Миний төхөөрөмж бас болсонгүй. Дэмжсэнд протоколд тэмдэглүүлье. Нийт 70 гишүүн буюу 78,7 хувиар Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах санал дэмжигдлээ. Микрофон авч үг хэлье. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Хоригийг хүлээж авъя гэдэг томъёололыг дэмжиж санал өгсөн, төхөөрөмж алдаатай заалт гараад эсрэг гарч байна. Тийм учраас протоколд дэмжсэнээр оруулж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Доржханд сайд, Дашдондогийн Ганбат гишүүн, Пүрэвийн Батчимэг гишүүн, Сэддорж гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүн нарыг дэмжиж санал өгсөнд протоколд тэмдэглэе. Ингээд “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурал 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” 38 дугаар тогтоол, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 39 дүгээр тогтоол, “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүрдүүвчид нэмэлт оруулах тухай” 40 дүгээр тогтоол, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 41 дүгээр тогтоолд бүхэлд нь тавьсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсугай.

2.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Аубакир гишүүн горимын санал.

**Т.Аубакир:** Баярлалаа. Хоригийг хүлээж аваад үндсэндээ болж байна. Одоо энэ хоригийг хүлээн авах тухай Их хурлын тогтоолыг эцсийн найруулгыг нь шууд батлах санал гаргаж байгаа юм. Яагаад гэхээр одоо төсвийн ажлын хэсэг гарч ажиллана. Орон нутгийн төсөв батлах асуудал маань тулчихсан байгаа. Тийм учраас өнөөдрийн хуралдаан дээр эцсийн найруулгыг сонссонд тооцох ажиллагааг өнөөдөр дуусгаж өгөөч гэсэн санал гаргаж байна. Горимын санал.

**Д.Амарбаясгалан:** Горимын санал гаргаж байна. Гишүүд дэмжиж байна уу. Тэгвэл Аубакир гишүүний гаргасан горимын саналаар “Ерөнхийлөгчийн хоригийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Даргын дэргэдэх зөвлөл шууд хуралдана.

17.32 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*